



Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах

2023 ОНЫ
ХУРААНГУЙ ТАЙЛАН
*Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүм*



Агуулга

- 3 Тэргүүн зөвлөлийн захиас
- 4 Бусдыг халамжлах бидний үүрэг
- 5 Нийгэмдээ үйлчлэх
- 6 Дэлхийн хөгжил дэвшил хүүхэд, эмэгтэйчүүдээс эхэлдэг
- 8 Сүмийн гишүүдийн бодит үйлдэл
- 10 Бусдад үйлчилж буй номлогчид
- 12 JustServe

ДЭЛХИЙ ДАЯАР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, САНААЧИЛГА

- 14 Үйл ажиллагааны хураангуй тайлан
- 16 Яаралтай тусламж
- 18 Цэвэр ус ба ус цэвэрлэгээ
- 19 Боловсрол
- 20 Хөдөлмөр эрхлэлт
- 22 Байгаль орчныг хамгаалах
- 23 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба хөдөлгөөний бэрхшээл

- 24 Өлсгөлөнтэй тэмцэх
- 26 Орон байрны дэмжлэг үзүүлэх
- 27 Сэтгэцийн эрүүл мэнд
- 28 Бие даах чадвар хөгжүүлэх

ДЭЛХИЙ ДАЯАР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

- 30 Африкт
- 32 Азид
- 34 Австрали, Филиппинд Номхон далайн бүс нутагт
- 35 Карибын тэнгисийн бүс нутагт
- 36 Төв Америкт Өмнөд Америкт
- 38 Европт
- 39 Ойрх Дорнодод
- 40 Хойд Америкт

ТАНД БАЯРЛАЛАА

ЭХ СУРВАЛЖ

Нүүр хуудас (цагийн зүүний дагуу дээрээс доош): Хүүхдүүдийн гэрийн даалгаварт тусалж буй залуу эрэгтэй; Хонконг дахь нэгэн ээж, охин хоёр; Энэтхэгт хараа зүйн тусламж авч буй гэр бүл; Нар жаргахыг хараад мишээж буй залуу эмэгтэй; Мавар хар салхины дараа Гуамын нийгэмд цэвэрлэгээ хийж буй Сүмийн гишүүд; Йеменд хандивласан орогнох байрны эд зүйлс дээр сууж буй хүүхэд; Шэлтэрбокс (ShelterBox)-ийн гэрэл зураг; Цэвэр усанд тоглож буй хүүхдүүд; Ватер-Эйд (Water-Aid)/ Жэрри Галиагийн гэрэл зураг; Хоол тэжээлийн байдлын үзлэгийн үеэр хүүхдээ тэвэрч буй эх; Дэлхийн хүнсний хөтөлбөрийн гэрэл зураг.



Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон өөрийн хоёр зөвлөх болох ерөнхийлөгч Даллин Х.Өүкс, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг нарын хамт.

Эрхэм найз нар аа,

Есүс Христ энэ дэлхий дээр амьдарч байхдаа Бурхан Эзэнээ хайрла, “хөршөө өөрийн адил хайрла” (Матай 22:39) гэсэн агуу хоёр тушаалыг өгсөн билээ. Биднийг Бурханд хайраа харуулахыг эрэлхийлэх үед бидний зүрх сэтгэл аяндаа бусдын сайн сайхны төлөө хандаж байдаг. Христ өвчтэйг эдгээж, өлссөнийг хооллож, нүцгэнийг хувцаслаж, дорой нэгнийг халамжлан, хөршөө хайрлах үлгэр жишээг Өөрийн биеэр үзүүлсэн.

Бид тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавих ариун нандин ажлыг үргэлжлүүлэхийн төлөө хэрэгжүүлж буй ажлынхаа хураангуй тайланг та бүхэнд хуваалцахдаа даруусаж байна. Тус хураангуй нь Сүмийн гишүүдэд дэмжлэг үзүүлсэн эх үүсвэр, үйлчлэл зэргийг багтаасан ба дийлэнх хэсэг нь дэлхий даяарх Бурханы бүх хүүхдийн төлөө үзүүлж буй хүмүүнлэгийн тусламжийг тайлбарлахад зориулагдсан болно. Есүс Христийн дагалдагчдын хувьд бид энэ ажлыг үүрэг, баярт завшаан гэж үздэг. Энэ ажлыг урагшлуулж, хүрээгээ тэлэх боломжийг олгож буй Сүмийн гишүүд, найз нөхөд, бусад итгэл даасан байгууллагын харамгүй зориулсан цаг хугацаа, хувь нэмрийн төлөө бид талархаж байна.


Бурхан Өөрийн бүх хүүхдийг хайрладаг гэдэгт бид бүрэн дүүрэн итгэдэг. Хөршүүддээ анхаарал халамж тавьж, тусламж хэрэгтэй үед нь тэднийг тайтгаруулан, Бурханы авралын ажлыг урагшлуулахад тусалдаг сайн хүмүүс хаа сайгүй бий. Бидний бие биеэ хайрлаж, нэг нэгэндээ үйлчлэх энэ ажилд та бүхнийг нэгдээрэй хэмээн урьж байна. Их Эзэн энэ агуу ажлыг үргэлжлүүлэн адислаасай хэмээн бид залбирч байна.

Тэргүүн зөвлөл

Russell M. Nelson

Dallin H. Oaks

Henry B. Eyring



Кени улсын Ифо дүрвэгсдийн хуаранд байрлаж буй хүмүүс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Дэлхийн хүнсний хөтөлбөртэй хамтарсан төслөөр дамжуулан тусламж хүлээж авсан.

“Би өөрсдийнхөө жижиг ч гэсэн арга замаар яваад; сэтгэлийн дарамттай, ганцаардсан, өлссөн, ойлгоход бэрх өвдөлт шаналлыг мэдэрч буй, сэтгэлдээ шаналж буй хүмүүсийг хаа байгаа захаас нь олж аван, тэднийг халамжлахын тулд чадах бүхнээ хийдэг хүмүүсийг хүндэтгэн мэхийж байна.”

—АХЛАГЧ ПАТРИК КИЙРОН,
АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГА

Бусдыг халамжлах бидний үүрэг

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм тоо нь байнга өсөн нэмэгдэж буй тусламж хэрэгтэй Бурханы хүүхдүүдэд өргөн цар хүрээнд анхаарал халамж тавихыг эрмэлздэг. Уг дэмжлэг халамж, бие даах чадвар хөгжүүлэх ажил, хүмүүнлэгийн тусламж, сайн дурын үйлчлэлээр дамжуулан хэрэгждэг.

Халамж, бие даах чадвар хөгжүүлэх ажил

Халамж, бие даах чадвар хөгжүүлэх ажил нь мацгийн өргөлийн тусламж, хоол хүнсний захиалга, боловсролын хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, сэтгэл санааны эрүүл мэндийн дэмжлэг зэрэг олон үйлчилгээг багтаадаг ба эн тэргүүнд Сүмийн гишүүдэд үр өгөөжөө өгдөг.

Хүмүүнлэгийн ажил

Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах Сүмийн ажлын хамгийн том өсөлт нь хүмүүнлэгийн тусламжаар дамждагт оршдог. Сүм нь санхүүжилт, эд бараа хандивлан, олон мянган хүмүүнлэгийн төсөлд дэмжлэг үзүүлдэг. Эдгээр төсөл нь арьс өнгө, яс үндэс, шашны харьяаллаас үл хамааран дэлхий даяарх Бурханы олон сая хүүхдэд ашиг тусаа өгдөг.

Сайн дурын үйлчлэл

Сүмийн гишүүд, найз нөхдийн үзүүлдэг энэрэнгүй үйлчлэл нь халамж, бие даах чадвар хөгжүүлэх, хүмүүнлэгийн ажлын амин чухал хэсэг юм. Сайн дурын үйлчлэл нь нийгэмд тусламж хэрэгтэй хүмүүст мөн адил тусалдаг, Сүмийн гишүүд “нэг нэгнийхээ ачааг үүрэлцэж; ... гашуудах тэдний хамт гашуудаж; ... мөн тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах” (Мозая 18:8–9) хүсэл эрмэлзэлтэй байдаг. Энэ нь биднийг Есүс Христтэй илүү адил болоход туслах чухал хэсэг юм.



Зүүн гар талд: Хөридөө хүнс худалдаж авахад нь туслах замаар үйлчилж буй Аргентины залуу эмэгтэй Баруун гар талд: Хамтдаа ногоо тарьж буй Япон дахь эмэгтэйчүүд

Нийгэмдээ үйлчлэх

Бид Мозая 2:17-р шүлгээс “та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа хэрэг” гэдгийг сурдаг. Бид тусламж хэрэгтэй нэгнийг халамжлах тулгуур зарчмыг дагаснаар Бурханд болон бусдадаа үйлчлэх эрхэм дээд зорилгоо илүү сайн гүйцэлдүүлэх боломжтой болдог.

Дэлхий даяар тусламж хэрэгтэй хүмүүс олон хэдий ч бид нийгэм, орчин тойрон, гэр бүлээ хөгжүүлэх үед энэ нь урт хугацааны хамгийн үр дүнтэй өөрчлөлтийг авчирдаг. Ямар ч байдлаар үйлчилж байсан дараах зарчмуудыг бодож үзээрэй. Үүнд:

1. Хэрэгцээг нь таньж мэд

Нийгэмд тусламж хэрэгтэй хүмүүс байдаг.

- Сүмийн удирдагчид, хөршүүдээсээ тэдний мэддэг үйлчлэх боломжуудын талаар асуу.
- Амьдардаг газрынхаа ашгийн бус байгууллагын талаар суралц. Хэрэв ашиглах боломжтой бол амьдардаг газрынхаа төслүүд, ашгийн бус байгууллагуудыг олохын тулд JustServe.org вэбсайтыг ашигла.

2. Утга учиртай харилцааг бий болго

Ихэвчлэн шашны харьяалал, гарал түүхээрээ ялгаатай хүмүүстэй хамтран ажилласан тохиолдолд хамгийн үр дүнтэй үйлчлэл бий болдог. Таны үйлчилдэг хүн бүр Бурханы хүүхэд бөгөөд нөхцөл байдлаасаа үл хамааран тэд ойлгогдож, хайрлагдаж, хүндлэгдэх эрхтэй гэдгийг санаарай.

- Төслийг бус хүнийг эн тэргүүнд тавь.
- Өөрийн таамаглалыг өөгшүүлэлгүй, ялгаварлан гадуурхах үзлийг хойш тавьж, туслахыг эрэлхийлж буй хүмүүст тань

тулгарсан саад бэрхшээлийг чин сэтгэлээсээ ойлгохыг эрэлхийл.

- Бусдад тусламж үзүүлэх нь гол зорилго гэдгийг санаж, *үйлдлээрээ* итгэл бишрэлээ харуул. Сайн үйлсээрээ үлгэр жишээ үзүүл!

3. Төлөвлөгөө гарга

Нэн даруй шийдвэрлэх шаардлагатай хэрэгцээг хангах, бие даах чадвар хөгжүүлэх хоёрт хөтлөх шийдлүүдийг төлөвлө. Дараах асуултыг асуух замаар үйлчилж буй хүмүүсээрээ шийдэл гаргуул. Үүнд:

- *Та энэ хэрэгцээг шийдвэрлэхийн тулд юу хийсэн бэ?*
- *Та юу хийхийг хүсэж байна вэ?*
- *Хаана хэзээ ямар байдлаар тусламж авахыг хүсэж байна вэ?*

4. Туршлагаа хуваалц

Таны үйлчлэл танд болон бусдад хэрхэн нөлөөлсөн тухай туршлагаа хуваалцсанаар бусдыг мөн адил үйлдэхэд урамшуулж болно.

- Өдөр тутмын яриандаа үйлчлэлээс ирдэг баяр баясгалангийн талаар бусдад хуваалц. Бусдыг тантай нэгдэхэд урь.
- Сошиал медиа дээр хүмүүнлэгийн ажил таны болон таны үйлчилсэн хүмүүсийн амьдралыг хэрхэн адисалсан тухай жишээнүүдийг хуваалц.
- Дэмждэг ашгийн бус байгууллагуудаа дагаж, үйлчлэлийн түүхүүд дээрээ тэднийг тэмдэглэж оруул.



Хүүхдүүдээ тэвэрч буй ээжүүд.

**Хүүхэд, эмэгтэйчүүд рүү
чиглэсэн хүмүүнлэгийн
төсөл - 921**

**Хүүхэд, эмэгтэйчүүд рүү
чиглэсэн төсөл хэрэгжсэн
улсын тоо - 114**

*“Бид гэр бүлүүдийг
хүчирхэгжүүлэхийг хүсдэг . . .
Илүү их ойлголт, нөөц бололцооны
тусламжтайгаар [хайраар дүүрэн
эцэг эхчүүд] удаан үргэлжлэх үр
нөлөө бүхий өөрчлөлтийг хийхэд
илүү бэлтгэгддэг.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ КАМИЛЛ Н.ЖОНСОН
ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ
ЕРӨНХИЙЛӨГЧ²

Дэлхийн хөгжил дэвшил хүүхэд, эмэгтэйчүүдээс эхэлдэг

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Бурханаа хайрла, хөршөө хайрла гэсэн Аврагчийн өгсөн агуу хоёр тушаалыг дагахад итгэдэг. Бид энэхүү итгэл үнэмшлийнхээ дагуу үр нөлөөгөө нэмэгдүүлэхийг эрмэлздэг ба улмаар бидний гаргаж буй хүчин чармайлт зөвхөн тусламж хэрэгтэй хүмүүсээс гадна тэдний нийгэм, гэр бүлүүдийг адисалж байдаг.

Энэ загварыг хөгжүүлэхийн тулд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхий даяарх хүүхэд, эмэгтэйчүүдийг халамжлах ажлыг эн тэргүүнд тавихын чухал ач холбогдлыг ойлгодог. Бид нэг эмэгтэйд туслахдаа түүнийг хүүхдүүдийнхээ амьдралыг болон эргээд нийгмээ адислах хэрэгслүүдээр хангадаг. Хүүхдүүдэд анхаарал халамж тавих ажлыг эн тэргүүнд тавьснаар бид ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийдэг. Харин эрэгтэйчүүд, эцгүүдийг энэ ажилд оролцуулснаар бид гэр бүл, нийгмийг тэр чигээр нь бэхжүүлж байдаг.

Хүүхдийн хоол тэжээл

Сүм 2023 онд янз бүрийн гарал түүхтэй бүх хүүхдийг хоол тэжээлээр хангах ажлыг эн тэргүүнд тавьсан ба Кэйр (CARE), Хэлэн Кэллэр Интернэйшнл (Helen Keller International), Католик Релиф Сэрвисэс (Catholic Relief Services), Хүүхдийг Ивээх Сан, Хангэр Прожэкт (the Hunger Project), НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн хүнсний хөтөлбөр зэрэг итгэл хүлээсэн байгууллагуудад харамгүй их хандивын дэмжлэг үзүүлсэн. Энэхүү дэмжлэгээр дэлхийн өнцөг булан бүрд буй олон зуун мянган хүүхэд, эхэд тэжээллэг хоол, дархлаажуулалт, эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээг хүртэхэд нь тусалсан.

Сүм эдгээр хандиваас гадна хүүхдийн хоол тэжээлийн дуталд орох эрсдэлтэй Сүмийн гишүүдийн хүүхдүүдэд туслахад чиглэсэн өөрсдийн хоол тэжээлийн хөтөлбөрийг мөн адил хэрэгжүүлсэн. Түүнчлэн Сүм дэлхий даяарх хэд хэдэн бүс нутагт олон нийтийн хүнсний ногооны газрыг байгуулж,



Эх, хүүхэд хоёр Кени дэх дүрвэгсдийн хуаранд тэжээллэг хоол хүнс хүлээн авч буй нь. Дэлхийн хүнсний хөтөлбөрийн гэрэл зураг.

хоол тэжээлийн байдлын үзлэг хийхэд туслах тоног төхөөрөмж хандивласан.

Эх, нярайн асаргаа

Сүм 2023 онд эх нялхсын эндэгдлийн тоог бууруулах тал дээр ажиллаж, эх, нярайд илүү сайн асаргаа хийх нөхцөлийг бүрдүүлсэн. Сүм НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын ажиллагаагаар дамжуулан Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Хаити, Мали, Мозамбикийн хүүхэд, эхчүүдэд зориулж боловсронгуй эрүүл мэндийн дэд бүтэц, дархлаажуулалтын дэмжлэг үзүүлэх боломжтой болсон.

Филиппин, Ганад болон дэлхий даяарх бусад хэд хэдэн бүс нутагт яаралтай тусламж хэрэгтэй шинээр төрсөн нярайд асарч буй эмч нарт туслах нярайн тоног төхөөрөмжийг хандивласан. Сүм түүнчлэн Америкийн Нэгдсэн Улсад Нэйшнл Асосиэшн фор дэ Адвансмент оф Колорд Пийпл (National Association for the Advancement of Colored People) (NAACP)-тэй хамтран жирэмсэн эхчүүдэд нярай хүүхдүүдээ хэрхэн асрах талаар суралцахад туслах Май Бэйби Фор Мий (MyBaby4Me) хөтөлбөрийг удирдах, санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Уг ажлын үр дүнд эхийн эндэгдлийн түвшнийг болон эрүүл мэндийн урт хугацааны хүндрэлийг бууруулж, дэлхий даяарх дутуу төрсөн нялхас, хүнд өвчтэй нярай хүүхдүүдийн эсэн мэнд үлдэх боломжийг сайжруулахад туслалцаа үзүүлсэн.

Боловсрол

Сүм 2023 оны туршид дэлхийн өнцөг булан бүрийн өөр өөр гаралтай эмэгтэйчүүд, хүүхдүүдийн боловсролыг дээшлүүлэхэд үргэлжлүүлэн өндөр ач холбогдол өгсөн.

Сүмийн хэрэгжүүлсэн бусад ажлын дунд Сүм Перу улсын Арэкипа дахь Каритас байгууллагатай хамтран өрх толгойлсон эмэгтэйчүүдийн бие даах чадварыг нэмэгдүүлсэн. Энэ төслийн хүрээнд эмэгтэйчүүд гэр бүлийнхээ хэрэгцээг илүү сайн хангах, шинэ ур чадвар хөгжүүлэх мэргэжлийн

сургалтад хамрагдсан. Сүм түүнчлэн анги танхимын засварын ажлыг удирдан явуулж, дэлхий даяарх хүүхдүүдэд боловсрол эзэмших хүртээмжийг дээшлүүлэхэд зориулсан тоног төхөөрөмж хандивласан.

Үйлчлэх боломжууд

Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхийг эрэлхийлдэг Сүмийн нэг арга зам нь тэдэнд үйлчлэл хийх боломжуудыг олгох явдал байдаг. Энэ нь үндсэндээ тусламж хэрэгтэй гэр бүл, хувь хүмүүст анхаарал халамж тавих үүрэгтэйгээр үүсгэн байгуулагдсан Сүмийн эмэгтэйчүүдийн байгууллага болох Халамжийн нийгэмлэгээр дамжуулан хэрэгждэг. Халамжийн нийгэмлэг нь дэлхий даяарх цуглаануудад оролцдог гишүүдийн хамт орон нутагтаа анхан шатны ажлыг зохион байгуулахад онцгой байр суурь эзэлдэг. Энэ нь тусламж хэрэгтэй хүмүүст зориулж агуу үйлсийг бүтээхэд орон нутгийн байгууллага, өөр өөр шашин шүтлэгтэй эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах илүү их боломжийг эмэгтэйчүүдэд олгодог.

Нийгэм, гэр бүлүүдийг бэхжүүлэх

Хүүхдийн эрүүл мэнд, аж байдлыг сайжруулахад бүхэл бүтэн гэр бүл оролцдог. Гэр бүлийг бэхжүүлэх, бие даах чадварыг хөгжүүлэхийн төлөө хэрэгжүүлж буй ажил болгон үр хүүхдийн амьдралд, бүр цаашилбал нийгмийн маань ирээдүйд эерэг нөлөө үзүүлдэг. Сүм 2023 онд олон мянган хүмүүнлэгийн төслийг удирдан, суралцах эх сурвалж, хөтөлбөрүүдээр хангаж, зөвхөн Сүмийн гишүүдээс гадна Бурханы бүх хүүхдийг өргөн дэмжиж, хүчирхэгжүүлэхийн төлөө тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавих ажилд дэлхий даяарх гишүүдээ оролцуулсан. Эцэг эх, асран хамгаалагч нарт энэхүү тусламжийг үзүүлснээр хүүхдэд өсөж хөгжихөд шаардлагатай халамжийг үзүүлэхэд гэр бүлүүдийг илүү сайн бэлтгэж чадна гэдэгт бид найддаг.



Гуам дахь Сүмийн гишүүд Мавар хар салхины дараах цэвэрлэгээнд оролцож буй нь.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Бурханаа хайрла, хөршөө хайрла гэсэн Аврагчийн өгсөн агуу хоёр тушаалыг дагахад итгэдэг. Гишүүд тохинууллаар дамжуулан хайраа үзүүлдэг.

Тохинуулах гэдэг нь хэн нэгний хэрэгцээг ойлгож, анхаарахыг хэлдэг. Бид харьяа газрынхаа цуглаанд оролцож буй хүмүүст тохинуулахаас гадна олон нийтийн төсөл, бусад санаачилгаар дамжуулан өөр өөр шашин шүтлэгтэй хүмүүст үйлчлэх боломжуудыг залбирч эрэлхийлдэг.

Бид амьдарч буй газар, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэгийн итгэл үнэмшил эсвэл улс төрийн хамаарал зэргээс үл хамааран хариу нэхэлгүй, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжилснаар Есүс Христийн үлгэр жишээг дагахыг хичээдэг.

Сүмийн гишүүдийн бодит үйлдэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах ажилд амин чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүмийн гишүүд Бурханаа хайрлах, хөршөө хайрлах гэрээний нэг хэсэг болгон Сүм дэх тусламж хэрэгтэй гэр бүл, хувь хүмүүст туслахын тулд сар бүрийн нэг өдөр мацаг барьж, идээгүй алгассан хоолныхоо мөнгийг өгөөрөөр хандивладаг.

Үүнээс гадна Сүмийн гишүүд нийгэм, хөршүүддээ тохинуулж, Бурханы хүүхдүүдэд туслахаар өөрсдийн цаг зав, авьяас билэг, хайр энэрэл, материаллаг зүйлс, санхүүгийн хэрэгслийг “Их Эзэний агуулах”-ын нэг хэсэг болгон хандивладаг.

Яаралтай тусламж

Гай гамшиг тохиолдох үед Сүмийн гишүүд цаг зав, эрч хүчээ шашин шүтлэгээс эсвэл гарал түүхээс үл хамааран гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслахад зориулдаг. Жишээлбэл: Гишүүд, номлогчид Шинэ Зеландад засгийн газрын бүлгүүд, хөршүүдтэй хамтран Габриэлл хар салхинд нэрвэгдсэн хорооллуудыг цэвэрлэв. Үерийн улмаас Өмнөд Солонгосын Хойд Чунчонг аймаг ихээхэн хохирол амсахад Сүмийн гишүүд үйлчлэл хийж, нэн даруй дэмжсэн. Насанд хүрсэн болон өсвөр үеийн сайн дурын хүмүүс хамтдаа байшингийн эвдэрсэн тавилга, хог хаягдлыг цэвэрлэхэд гар бие оролцсон.

Халамжийн нийгэмлэг

2023 онд Сүмийн эмэгтэйчүүд дэлхийд сайн үйлс бүтээхэд агуу том хөдөлгөх хүч болсон. Баруун Африкт Халамжийн нийгэмлэгийн эмэгтэйчүүд эргэн тойрны орчноо цэвэрлэх төслийг Гамбиа дахь Муслим шашинтай эмэгтэйчүүд болох “Дайчин эмэгтэйчүүд” бүлэгтэй хамтдаа зохион байгуулсан. Мөн Перугийн Халамжийн нийгэмлэгийн гишүүд Лимад болсон сүйрэл дагуулсан үерт нэрвэгдсэн хүмүүст зориулж хоол хүнс, ус, ариун цэврийн цаас, хувцас зэргийг цуглуулсан.



Залуу эрэгтэйчүүд харьяа газрынхаа Дээрэт Индастрийс дэлгүүрт хандиваар ирсэн юмс ангилахад цаг заваа сайн дураараа зориулдаг.

Залуучууд

Сүмийн залуучууд тусламж хэрэгтэй хүмүүст энэрэнгүй үйлчлэл хийх агуу том чадавхтай билээ. Жишээлбэл: Юта мужид олон мянган залуу хамтдаа цуглан, Сая сая хоол хэмээх төсөлд зориулж хоолны иж бүрдэл цуглуулсан. Энэ залуус чин сэтгэлийн үйлчлэлээр дамжуулан өлссөн хүүхдүүдийг хооллохын төлөө нэг сая хоол савлах гэсэн Ютагийн Хүнс Хандивлах Сангийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Берлин хотод залуу гишүүд, Сүмийн найзуудаас бүрдсэн 700 гаруй хүн 2023 оны Тусгай Олимпыг дэмжихээр Европ даяарх үйлчлэлийн чуулганд цугласан. Тэд тухайн өдрийн туршид тусгай хэрэгцээтэй хүмүүст зориулсан спортын арга хэмжээг зохион байгуулахад туслахаар сайн дураараа өөрсдийн цаг завьг зориулсан.

Хүүхэд, өсвөр үеийнхэн

Үйлчлэл бол сүмийн хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхнийг нэгтгэх хүчин зүйл юм. Жишээлбэл: Панамд Сүмийн Хүүхдийн хэсгийн хөтөлбөрийн гишүүд СОС (SOS) хүүхдийн хотхоноор зочилсон. Уг байранд тэд бусад хүүхэдтэй хамт тоглож, амар амгалан, итгэл найдварын захиасыг хуваалцав. Түүнчлэн Хавай дахь Сүмийн өсвөр үеийн гишүүн Мариэлл Филиппиний Хавайн өсвөрийн мисс байр сууриа ашиглан, тусламж хэрэгтэй 100 гаруй сурагчид зориулж хичээлийн хэрэгсэл цуглуулжээ.

Америкийн Нэгдсэн Улсад Сүмийн өсвөр үеийнхэн нийгэмдээ хэрэгтэй үйлчлэлийг хэрэгжүүлэхээр клубүүдэд тусалсан. Даллас, Тиэрнан нар Колорадогийн сургуульдаа клуб эхлүүлж, өөр өөр шашны бүлгийн олон тооны өсвөр үеийн гишүүний анхаарлыг татжээ. 2023 онд хэрэгжүүлсэн бусад төслийн дотор тус клуб олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнг хадгалж үлдэхэд тусалж, асрах газрын өвчтөнүүдэд зориулан ноосон хөнжил хийн, нийгэмд нь хоргодох газар хайж буй хувь хүмүүст тусалсан.

“Эргэн тойрноо ажигла. Та хаана хувь нэмрээ оруулж болох вэ? Та хаана хайраа үзүүлж болох вэ? Та хаана үйлчилж болох вэ? Тэр таныг ямар нэг учир шалтгаанаар энд илгээсэн ба танд эрхэм зорилго, үүрэг бий.”

—КРИСТИН М.ЕИЙ ЭГЧ,
ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН
ХОЁРДУГААР ЗӨВЛӨХ³

Сүмийн олон гишүүн орон нутгийнхаа нийгэмд үйлчилдэг бол зарим нь хүмүүнлэгийн ажилд илүү их цаг заваа зориулахыг сонгодог. Олон ахмад номлогч, залуучууд үйлчлэлийн номлолын үүрэгт ажилд хагас цагаа зориулж, нийгмийн хүрээллийнхээ тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах төслүүдийг зохион байгуулж, оролцдог.

Гэрлэсэн хосууд бүрэн цагаар халамж, бие даах чадварын төсөлд үйлчлэхийг сонгож болно. Эдгээр хос цаг заваа хуваарилагдсан бүсийнхээ хүмүүнлэгийн төслүүдийг удирдахад зориулдаг.

Бүрэн цагийн номлолын номлогчид Аврагчийн тухай заах ажлаас гадна тохинууллынхаа хүрээнд үйлчлэлийн төсөлд оролцдог. Эдгээр номлогч үүссэн онцгой байдлын тусламжийн ажиллагааг хэрэгжүүлэхэд тусалдаг.

“Их Эзэнд болон бусдадаа үйлчлэх дуудлагууд нь . . . нигүүлсэл, чадавх, даруу байдлаа нэмэгдүүлэх боломжийг олгодог.”

—АХЛАГЧ ГЭРРИТ В.ГОНГ,
АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ЧУУЛГА⁴

Бусдад үйлчилж буй номлогчид

Үйлчлэлд зориулсан санаачилгууд

Номлогчид номлолынхоо туршид төрөл бүрийн үүрэг даалгаварт үйлчлэх боломжтой байдаг. Жишээлбэл: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний номлогчид Сүм дэх хувь хүмүүст хөдөлмөр эрхлэх боломж олох, үүнд бэлтгэхэд тусалдаг. Номлогчид Сүмийн эзэмшлийн жимсний цэцэрлэг, фермийн аж ахуй, бишопын агуулах, Шилжилтийн үйлчилгээний албанд үйлчилж болно. Зарим номлогч түүнчлэн харьяа газрынхаа ашгийн бус байгууллагуудтай хамтран үйлчлэлээр хангах, төслийн зохицуулалт хийх зэргээр хүмүүнлэгийн ажилд үйлчилдэг.

Гамшгийн тусламж

Жил бүр олон сая хүн гамшиг, онцгой байдалд өртдөг. Урьдчилан таамаглаагүй үйл явдлуудад туслалцаа авахад ихэвчлэн номлогчдыг дууддаг. Тэд гамшигт өртөж болзошгүй хэн бүхэнд өгөөмөр үйлчлэлээр дамжуулан итгэл найдвар дахин олж авахад нь тусалдаг.

Жишээлбэл: Эквадор улсын Эсмэралдас аймаг хүчтэй үерт нэрвэгдсэний дараа номлогчид зовж шаналж буй хүмүүст туслахын тулд замдаа гурав гаруй цаг явсан. Тэд шуурганд эвдэрсэн гудамж, гэр орон, эд хогшлын шаврыг хүрздэж авахад тусалсан.

Гуамд номлогчид бусад сайн дурынхантай нэгдэн, Мавар хар салхины хүчтэй салхи, борооны улмаас нурсан байшин, орон нутгийн бизнесүүдэд туслалцаа үзүүлсэн. Тэд хог хаягдал цэвэрлэх, эвдэрсэн дээврийг засварлах, үндэс нь ил гарсан моддыг цэвэрлэх, цэвэр ус түгээх, тусламжийн ажлыг зохицуулахад тусалдаг. Мөн тэд гамшгийн улмаас хувийн эд зүйлээ алдсан олон хүнд цэвэр хувцас хунар тараасан.

Олон нийтийн үйлчлэл

Номлогчид зааж, үйлчилж, амьдардаг газартаа туслахын төлөө цаг зав, хүчин чармайлтаа зориулдаг. Эдгээр хүчин чармайлт нь тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, нийгмийг янз бүрийн арга замаар хүчирхэгжүүлэхэд тусалдаг. Жишээлбэл: Вашингтон Ди Си дэх бүрэн цагийн номлогчид Смитсоны ардын урлагийн наадам дээр үйлчлэл хийсэн. Уг үйлчлэл орчин үеийн соёл уламжлалыг нийгэмд түгээж, өөр өөр шашин шүтлэг, гарал түүхтэй хүмүүсийг нэгтгэхэд тусалсан.

Панам дахь номлогчид бусад сайн дурынхантай хамт цуглан, нэг өдрийн үйлчлэл хийж, далайн эргийг цэвэрлэн, хоол хүнс, бусад хэрэгцээт зүйлийг цуглуулж, хувийн эрүүл ахуйн иж бүрдлийг түгээн, ахмад настны асрамжийн газарт үйлчилсэн.

Ахлагч Дийн Нивадагийн Хараагүйчүүдийн төвд байгууламжийн засвар үйлчилгээ үзүүлэх дэмжлэгээр дамжуулан нийгэмдээ үйлчилдэг. Ахлагч Дийн “Би үлдсэн амьдралаа . . . зөвхөн өөрийнхөө төлөө зориулахаас илүүтэйгээр бусдад туслахад зориулахыг хүсэж байна”⁵ гэж хэлэв.



Дээд талд: Францад эмэгтэй номлогчид нэгэн эмэгтэйд хайрцаг баглаж, зөөхөд тусалж буй нь. Зүүн гар талд: Үйлчлэлийн номлогч Сүмийн Глобал үйлчлэлийн төвд үйлчлэл хийж буй нь. Баруун гар талд: Ахмад эмэгтэй номлогчид 12 алхамт хөтөлбөрийг эмэгтэй хоригдлуудад зориулан удирдаж буй нь. Баруун доод талд: Ахмад номлогч Юта мужийн Сүмийн түүхэн талбайн ландшафтын ажилд туслаж үйлчилж байгаа нь.

JustServe (Жаст Сөрв) хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой улс - 17

JustServe хөтөлбөрт 2023 онд шинээр нэмэгдсэн байгууллагын тоо - 2037

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Амьдардаг газартаа тусламж хэрэгтэй байгууллагын талаар олж мэд.
- JustServe вэбсайтыг амьдардаг газартаа ашиглах боломжтой эсэхийг шалга.
- JustServe.org вэбсайтаар зочилж, бүртгүүлээд, уг хөдөлгөөнд нэгдээрэй!

“JustServe нь . . . гэрээнийхээ дагуу амьдрах бидний арга зам, хөдөлгөөн . . . [мөн] [манай] гишүүдийг адисалж, хүчирхэгжүүлдэг.”

—БИШОП ЖЭРАЛД КОССЭЙ,
ТЭРГҮҮЛЭХ БИШОП⁶

JustServe

JustServe хөтөлбөр бол амар амгалан, хайр, эв нэгдлийн уур амьсгалыг нийгэмдээ бүрдүүлэхэд зориулсан хөдөлгөөн юм. JustServe нь сайн үйлсийг хуваалцсанаар итгэл найдвараар урамшуулахаас гадна эерэг үр нөлөө, эв нэгдлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлэг, хувь хүмүүсийг харьяа газруудынх нь төслүүдтэй холбодог. JustServe хөтөлбөр нь олон янзын байгууллага, сургууль, итгэлд суурилсан байгууллагуудтай хамтран үйлчлэлийн уур амьсгалыг дэлгэрүүлэх, үр дүнтэй өөрчлөлт гаргах зорилготой ажилладаг.

Наснаасаа үл хамааран үйлчил

Эван (10 настай) харьяа газрынхаа хүнс хандивлах санд чанамал дуусаж байгааг анзаарч, тэр даруй тун хурдан арга хэмжээ авчээ. Тэрээр ээжийнхээ тусламжтайгаар найз нөхөд, гэр бүлийнхнээсээ чанамал, цэлцгэнүүр хандивлахыг хүссэн бичлэг хийсэн ба энэ нь социал медиа дээр хурдацтай тархсан байна. Эваны сургуулийн найз нөхөд аль анги хамгийн их чанамлын шил цуглуулсныг үзэх тэмцээн зохион байгуулахад нэгджээ. Хүмүүс уг ажилд тун идэвхтэй оролцсоноор нийт 702 шил цуглуулсан байна. Эваны түүх нь наснаасаа үл хамааран ганцхан хүн ямар гайхалтай үр нөлөөг үзүүлж болдгийг харуулсан тод жишээ байлаа.

Байгаа газраасаа үйлчил

Тавдугаар сард Албэртад болсон ой хээрийн гал түймрийн үеэр нийгмийн гишүүд JustServe хэрэгслийг ашиглан, харьяа газрынхаа удирдагч, албаны хүмүүстэй хамтран оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэхэд туслалцаа үзүүлсэн. Төв Албэртагийн JustServe-ийн мэргэжилтэн Сара JustServe .org дээрх ой хээрийн түймрийг унтраахад зориулсан хуудсаар дамжуулан харилцаа холбоо, зохицуулалт хийхэд тусалжээ. Үүний үр дүнд өөр өөр газраас хүмүүс хандив өргөсөн хэдий ч түймэрт өртсөн оршин суугчид өөрсдөдөө хэрэгтэй байсан дэмжлэгийг авах боломжтой болсон.

Хөршдөө үйлчил

Матэрнал Ауткомс Маттэр Шаувэрс (Maternal Outcomes Matter Showers) (MOMS) аян нь 2023 онд Америкийн Нэгдсэн Улс даяар өрнөж, сайн дурын ажилтнууд JustServe хөтөлбөрийг ашиглан, сайн дурын үйлчлэлийг зохион байгуулсан байна. Чэнс тү Лөрн (Chance to Learn), Кокотайф Блайк (CocoLife.Black) зэрэг харьяа газрын байгууллагуудтай хамтран JustServe-ийн сайн дурын ажилтнууд төвийн бүс доторх олон хотод “шинэ хүүхдийн найр”-ыг төрөх гэж буй эхчүүдэд зориулан зохион байгуулсан. Үүний үр дүнд тухайн ээжүүд харьяа газрынхаа эх үүсвэрийг илүү сайн ашиглах боломжтой болж, улмаар эх нялхсын эрүүл мэндийн үр дүнг сайжруулав.



Зүүн гар талд: Олон шашны бүлгийн эмэгтэйчүүд нийгмийнхээ JustServe төсөлд хамрагдаж буй нь. Баруун гар талд: Эван сургуулийн найзуудтайгаа хамт хандивын чанамал, цэлцгэнүүрийн шилнүүдийг сургууль дээрээ цуглуулав.



Хүүхдүүд Гана дахь Либерийн дүрвэгсдийн хуаранд боловсрол эзэмшиж байна. Мэттью Кэйрс Фаундэйшн Скуул(Matthew Cares Foundation School)-ийн гэрэл зураг

ДЭЛХИЙ ДАЯАР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, САНААЧИЛГА

“Бид бусдын төлөөх үйлчлэлд оролцох үедээ өөрсдийгөө илүү бага боддог бөгөөд Ариун Сүнс бидэн дээр илүү хурдан ирж, аль хэдийн бидэнд хүртээсэн байсан энэрлийн бэлгийг хүлээн авах насан туршийн эрэл хайгуулд маань тусалдаг.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ХЭНРИ Б.АЙРИНГ,
ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН ХОЁРДУГААР ЗӨВЛӨХ

2023 оны үйлчлэлийн хураангуй тайлан



4119

2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ХҮМҮҮНЛЭГИЙН
ТӨСЛИЙН ТОО



\$1.36

тэрбум
доллар

ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ



6.2 сая ам
доллар

САЙН ДУРЫН
АЖИЛД
ЗАРЦУУЛСАН ЦАГ



191

ҮЙЛЧИЛСЭН УЛС
ОРОН, ГАЗАР НУТГИЙН
ТОО

ЗАРДАЛД:

Ерөнхийд нь үзүүлсэн тусламж

- Дэлхий даяарх хүмүүнлэгийн төслүүд
- Хоол хүнс, бусад бараа бүтээгдэхүүний хандив

Эн тэргүүнд Сүмийн гишүүдэд олгосон тусламж

- Мацгийн өргөлийн тусламж
- Бишопын бараа бүтээгдэхүүний захиалга
- Халамж, бие даах чадвар хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулсан үйлчлэлүүд

ҮЙЛЧЛЭЛД ЗАРЦУУЛСАН ЦАГ

- Сүмийн халамж, бие даах чадвар хөгжүүлэх үйлчилгээний барилга байгууламж дахь сайн дурын ажил (бишопын агуулах, лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэр, фермийн аж ахуй, жимсний цэцэрлэг, хөдөлмөр эрхлэлтийн төв гэх мэт.)
- Олон улс орны тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах номлолууд
- Сүмээс ивээн тэтгэсэн гамшгийн дараах цэвэрлэгээ зэрэг нийгэмд чиглэсэн үйлчлэлийн төслүүд

“Мэдээж, [эдгээр] тоо баримт нь бидний юу өгч, хэрхэн тусалдаг талаарх гүйцэд бус тайлан юм. Эдгээрт дуудлагат ажлынхаа хүрээнд нэг нэгэндээ тохинуулж, гишүүнээс гишүүнд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн хувь хүний үйлчлэлүүд ороогүй. Мөн энэхүү [хураангуй тайланд] гишүүдийн маань манай Сүмтэй албан ёсны харилцаагүй, энэрлийн тоо томшгүй олон байгууллагаар дамжуулан хувиараа үзүүлсэн тусламжийн талаар дурдаагүй болно.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ДАЛЛИН Х.ӨУКС,
ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ*

2023 оныг зурвасхан харвал



ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ХАЛАМЖЛАХ

Гишүүд, номлогчдын хийсэн үйлчлэлийн тоо

7959670

Дэлхий даяарх Халамжийн нийгэмлэгийн гишүүдийн тоо

11368

Халамж, бие даах чадвар хөгжүүлэх үйлчлэлийн номлогчдын тоо



JUSTSERVE

Нийгэмд чиглэсэн үйлчлэлийн хөтөлбөрийн тоо

119461

JustServe вэбсайтад шинээр бүртгүүлсэн хэрэглэгчдийн тоо

17502

JustServe вэбсайтад шинээр нэмсэн төслүүд



ДЭЛХИЙ ДАЯАР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

Дэлхий даяар хэрэгжүүлсэн төсөл, санаачилга

206

Цэвэр ус, эрүүл ахуй, ус цэвэрлэгээний төслийн тоо

415

Яаралтай тусламжийн төслийн тоо

601

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чиглэсэн төслийн тоо

64

Хөдөлгөөний бэрхшээлд чиглэсэн төслийн тоо

530

Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төслийн тоо



БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ

Хөтөлбөр, үйлчлэлийн тоо

530

Боловсролд чиглэсэн төслийн тоо

10112

Үйлчилсэн Дэээрэт Индастрийс (Deseret Industries)-ийн туслах ажилтны тоо

2926

Донтолтоос ангижрах долоо хоног тутмын уулзалтын тоо

110019

Бие даах чадвар хөгжүүлэх бүлгийн оролцогчдын тоо



Зүүн гар талд: Ой хээрийн гал түймэр унтраах тусламжид хандивласан хангамжийн зүйлсийг зөөж буй Мауи дахь Сүмийн гишүүн. Баруун гар талд: Флоридад хар салхины дараа сэргээн засварлах ажилд туслах хангамжийн зүйлсийг авч буй сайн дурын ажилтнууд.

Яаралтай тусламжийн төсөл - 415

Тусламж үзүүлсэн улс - 94

Нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүст үзүүлсэн яаралтай тусламжийн төсөл - 113

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Онцгой байдлын тусламж шаардлагатай нөхцөл байдалд тусламж үзүүлдэг байгууллагаар дамжуулан мэргэшсэн сайн дурын ажилтан бол.
- Болзошгүй онцгой нөхцөл байдалд бэлтгэхэд туслах онцгой байдлын хувийн төлөвлөгөө гарга.
- Амьдардаг газрынхаа дүрвэгсдийг дэмждэг ашгийн бус байгууллагатай холбогдон, тэдэнд хэрхэн тусалж болох талаар бод.

Яаралтай тусламж

Хямралын дараах тусламж үзүүлэхдээ хямралд өртсөн хүмүүсийн бие махбодын хэрэгцээг хангах тал дээр голдуу төвлөрдөг. Гэвч сэтгэл санааны асуудалтайгаа тэмцэж буй хүмүүсийг орхигдуулахгүй байх нь чухал юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм онцгой байдлын үед өртөж болзошгүй бүх хүнд бие махбодын болон сэтгэл зүйн тусламж үзүүлэхийг эрэлхийлдэг.

Сэтгэл санааны болон сэтгэл зүйн тусламж

Өнгөрсөн жил Мауи арлын Лахайнагийн бүс ой хээрийн гал түймэрт өртөж, ихэнх оршин суугч гэр оронгүй хоцорсон. Сүм яаралтай орогнох байраар хангаснаас гадна Гэр бүлд зориулсан үйлчилгээний зөвлөхүүдийг илгээж, гамшигт өртсөн Сүмийн гишүүдэд сэтгэл зүйн анхны тусламжийг үзүүлсэн. Зөвлөхүүд гэр бүлийн гишүүдээ болон гэр орноо алдаж мөн бусдын зовж шаналахыг харсан хүмүүсийг тайтгаруулах боломжтой байв.

Гэр бүлд зориулсан үйлчилгээгээр Украины дайнд өртсөн хүмүүст зориулж зайнаас сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх семинарыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Семинарын сэдвүүд дотор амьд үлдэгсдэд онцгой байдлын үеэр тайван байх арга замууд, зөв аргаар даван туулах чадваруудыг заах зэрэг багтсан. Тэд мөн гэмтлийн дараах стрессийн эмгэг гэсэн сэдвээр зайны форум зохион байгуулсан.

Гэр бүлд зориулсан үйлчилгээгээр мөн Сүмийн удирдагч, гишүүдийг *Сэтгэл санааны хувьд бэлтгэлтэй байхад туслах зөвлөмж, Сэтгэлийн тэнхээгээр дамжуулан бэлтгэлтэй байх нь зэрэг* эх сурвалжуудаар хангах тал дээр ажилласан. Эдгээр эх сурвалж нь хувь хүмүүсийг онцгой нөхцөл байдал болон амьдралын зовлон бэрхшээлтэй нүүр тулах үед сэтгэл санааны бэлтгэлтэй байхад нь тусалдаг.

Материаллаг тусламж

Туркийн өмнөд хэсэг, Сирийн хойд хэсгийн бүс нутгийг сүйрэлд хүргэсэн дараалсан газар хөтлөлтөд олон сая хүн өртсөн. Сүм тусламжийн олон байгууллагатай хамтран ажиллаж, тус сүйрэлд өртсөн бүсүүдэд нэн даруй тусламж үзүүлсэн. Сүм олон зуун түр байрлах угсармал байшинг болон



Зүүн гар талд: Йемен дэх орон гэрээсээ шилжин нүүлгэгдэж, хандивласан орогнох байрны материал дээр сууж буй хүүхэд. Шэлтэрбокс (ShelterBox)-ийн гэрэл зураг. Баруун гар талд: Калифорниад болсон үерийн дараа сайн дурын ажилтнууд хог хаягдлыг цэвэрлэж байхдаа алгаа цохилцож буй нь.

эвдрэлд орсон эмнэлгийн барилга байгууламжуудыг орлох таван явуулын хээрийн эмнэлгийг хагалгаа хийх нэгжүүдийн хамт барихад тусалсан.

Тавдугаар сард Малавигийн 36 өдрийн турш (түүхэнд бичигдсэн хамгийн удаан) үргэлжилсэн халуун орны шуургад өртсөн бүсээс олон мянган хүнийг нүүлгэн шилжүүлсэн. Сүм дан ганц майхан, хөнжил, явуулын хээрийн клиникээр хангаснаас гадна гэр орноо алдсан олон зуун нийгэмлэгийн гишүүнийг хоргодох байртай болгосон. Сүмийн гишүүд ийм хувь хүмүүстэй хоол хүнсээ хуваалцаж, гэр бүлийнхэнтэйгээ хамт байх боломжийг зарим хүнд олгохын тулд зорчих хөдөлгөөнийг зохицуулж, хүмүүсийг тохиромжтой орон байр олох хүртэл халамжилж ирсэн.

Израил, Газын зурвас дахь хүмүүнлэгийн тусламж

Зөрчилдөөнтэй бүсийг оролцуулаад дэлхий даяар хүмүүнлэгийн тусламжийг үзүүлэх гэсэн зорилгынхоо хүрээнд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Газын зурвас, Израил дахь олон улсын тусламжийн маш олон төлөөлөгчтэй хамтран бусад хэрэгцээг хангахын зэрэгцээ эмнэлгийн болон сэтгэцийн эрүүл мэндийн нэн чухал тусламж үйлчилгээнд зориулж ихээхэн хэмжээний санхүүгийн эх сурвалжаар хангасан.

“Хэн бидний хөрш вэ? Хүн болгон бидний хөрш. . . . Бид ямар ч нөхцөл байдалд хаанаас гаралтай, ямар арьс өнгө, шашин шүтлэгтэйгээс үл хамааран хүн бүрд хүрч ажилладаг. Бид чадахынхаа хэрээр хүн бүрийг адислахаар ирээд байна.”

—БИШОП В.КРИСТОФЭР ВАДДЭЛЛ, ТЭРГҮҮЛЭХ БИШОПЫН ЗӨВЛӨЛИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ¹⁰



Пакистанд нэгэн эх, хүүхэд хоёр гэр орон, эд зүйлсээ үерийн улмаас алдсаны дараа түр зуурын орогнох байранд буй нь. Шэлтэрбокс (ShelterBox)-ийн гэрэл зураг.

Цэвэр ус ба ус цэвэрлэгээ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хүмүүнлэгийн ажлын тэргүүлэх чиглэлийн хүрээнд цэвэр ус, ус цэвэрлэгээ, эрүүл ахуйн хувьд (WASH гэж нэрлэдэг) тусламж хэрэгтэй бүх хүнд дэмжлэг үзүүлэхийг эрмэлздэг. Энэ ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Сүм дэлхий даяарх болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ийм үйлчлэлийн хүртээмжтэй байдлыг сайжруулах, урт хугацаанд үйлчлэх шийдлээр хангах системийг бүхэлд нь хүчирхэгжүүлэх, бие даах чадварт дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Бүгдэд зориулсан цэвэр усны тогтвортой менежмент

Сүм Сьерра Леон улсын олон мянган нийгмийн гишүүнийг цэвэр усны хүртээмжтэй болгохын төлөө Ватэр-Эйд (WaterAid) байгууллагатай хамтран ажиллав. Уг төслийн үр дүнд оршин суугчид ус цэвэрлэгээний шаардлага хангасан үйлчилгээ, эрүүл ахуйн зөв хэвшлийн мэдлэгтэй болсон. “Тус сургалтын хүрээнд би хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөнд үргэлж хангалттай устай эсэхийг тогтмол шалгах байдлаар охидын сарын тэмдгийн эрүүл ахуйн менежментэд дэмжлэг үзүүлэх боломжтой болсон” гэж уг төсөл хэрэгжсэн сургуулиудын нэг болсон сургуулийн эрүүл мэндийн клубийн зохицуулагч Хава хэлэв.

ВАШ (WASH) төсөлд зориулсан нийгмийн ажил

Сүм 2023 онд Ватэр Фор Пийпл (Water for People) байгууллагатай хамтран Гватемалын ард иргэдэд ил задгай жорлонгүй болоход тусалсан. Уг төслөөр дамжуулан ард иргэд бүс нутгийн цаг агаарын хүнд нөхцөлд тэсвэртэй гэр бүлийн угаалгын өрөөг барихад туслах чанартай материалуудыг авах боломжтой болсон. Үүнтэй адилаар Сүм, Ватэр-Эйд байгууллага хоёрын хамтын ажиллагааны хүрээнд Папуа Шинэ Гвинейд болон Либерид нийгэм, сургуульд зориулсан аюулгүй ундны усны цоргыг суурилуулсан. Уг төслийн хүрээнд нөлөөлөлд өртсөн ард иргэдэд цоргыг хэрхэн ашиглах, арчлах тордох талаарх сургалтыг мөн адил олгосон.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Харьяа газрынхаа цэвэр ус, ус цэвэрлэгээний хэрэгцээг олж мэд.
- Амьдардаг газартаа ашиглах боломжтой цэвэр усны хүртээмж, үүнд хэрхэн хамрагдаж болох талаар суралц.

Цэвэр усны төсөл - 112

Ус цэвэрлэгээ, эрүүл ахуйн төсөл - 94

Төслүүдийг хэрэгжүүлсэн улс - 73

Үйлчлэлээр дамжуулан нийгэмлэгийг адислах

Болив улсын тариаланч Хорхэ нийгэмдээ цэвэр усаар хангах худгийн систем бий болгохыг үргэлж хүсдэг байв. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, Ватэр Фор Пийпл (Water for People) байгууллага хоёрын тусламжтайгаар түүний мөрөөдөл бодитой болсон юм.

“Ердөө цоргыг нээгээд л устай болох боломжтой болсон нь итгэмээргүй хэрэг” гэж Хорхэ хэллээ. Энэхүү шинэ худгийн ачаар хүүхдүүд сургуульдаа илүү цэвэр цэмцгэр, илүү чөлөөтэй явдаг болсон гэж Хорхэ мөн хэлж байлаа. Түүнчлэн орон нутгийн тариаланчид тариалангаа услах илүү их устай болсон. “Би энд амьдарч буй бүх гэр бүл устай болно гэдгийг мэдэх учир хэзээ нэг өдөр амар тайван нойрсох боломжтой боллоо” гэж тэр бээр хэллээ.⁹



Зүүн гар талд: Гараа угаах буй эмэгтэй, охин хоёр. Ватэр Фор Пийпл (Water for People)-ийн гэрэл зураг. Баруун гар талд: Зүүн Тиморт нэгэн эмэгтэй ач охиндоо цоргоноос цэвэр ус уухад нь тусалж буй нь. Ватэр-Эйд/Тариқ Хавари (WaterAid/Tariq Hawari)-ийн гэрэл зураг.

Боловсрол

Сүм дэлхий даяарх хүмүүст суралцах, өсөж хөгжих, бүрэн чадавхдаа хүрэхэд нь боломж бий болгох замаар цаашдаа бие даасан байдалд ахиц гаргахыг эрмэлзэж байна. Боловсрол ядуурал бууруулах, эрүүл мэнд сайжруулах, нийгмийг хүчирхэгжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Боловсролын ахиц эдийн засгийн өсөлт, зөрчилдөөнийг тайван замаар шийдэхтэй мөн адил холбоотой. Боловсрол итгэл найдвар төрүүлж, үйлдэлд хөтөлдөг.

Сүмийн гишүүдэд зориулсан эх сурвалжууд

Сүмийн гишүүдийн боловсролын зорилгыг дэмжих Сүмийн хоёр гол эх сурвалж

Эх үүсвэр нь **Тасралтгүй Боловсролын Сан (ТБС), БЯИС-Патвэй Ворлдвайд (BYU-Pathway Worldwide)** юм. ТБС нь суралцагчдыг ажилд орох, хувиараа хөдөлмөр эрхлэхэд эрэлт хэрэгцээтэй чадвараар хангадаг боловсролын хөтөлбөрүүдийг дүүргэхэд туслах санхүүгийн тусламжийн хөтөлбөр юм. БЯИС Патвэй Ворлдвайд суралцагчдадаа боломжийн үнээр илүү дээд боловсролыг онлайнаар олж авах боломжийг санал болгодог.

Сүмийн гишүүдэд хүртээмжтэй бусад боловсрол эзэмших эх сурвалжуудад:

- гишүүдэд хоол тэжээл, хөдөө аж ахуйн чиглэлээр дунд сургуулийн дараах боловсрол эзэмшихэд туслах **Бэнсоны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр (The Benson scholarship program)**,
- Сүмийн гишүүдийг болон бусдыг үнэ төлбөргүй англи хэлний сургалтаар хангадаг **EnglishConnect**-ийн хөтөлбөр орно.

Ерөнхий эх сурвалжууд

Сүмийн хүмүүнлэгийн төслүүдээр суралцагчдыг өндөр чанартай боловсрол олж авах илүү сайн боломжтой байхад нь туслах зорилгоор дасгалын ном, хичээлийн ширээ, сандал, багшийн сургалт, анги засвар, өөр олон зүйлээр хангадаг. 2023 онд хэрэгжүүлсэн боловсрол руу чиглэсэн бусад хэдэн зуун төслийн дотор Сүм нөөц эх үүсвэрээр дутмаг Тонга улсын хөдөө орон нутгийн сургуулиудад тоноглол, ном, бусад хэрэгслийг хандивлажээ.

Бэнсоны нэрэмжит тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан оюутан - 349

Боловсрол руу чиглэсэн төсөл - 530

Төслүүдийг хэрэгжүүлсэн улс - 97

Илүү сайхан ирээдүйг бий болгохын тулд боловсролыг санхүүжүүлэх

Аргентины Алфрэдо, Надиа хоёр мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцаж, илүү сайхан ирээдүйгээ бүтээх үү эсвэл боловсролын үнэтэй зардлаас татгалзаж, амьдралын хэв маягаа хадгалж үлдэх үү гэсэн шийдвэрээс сонгох хэцүү байдалтай нүүр тулжээ. Алфрэдог Тасралтгүй Боловсролын Сангийн талаар мэдэж авах хүртэл гэр бүлийн хос хоёрын ирээдүйн мөрөөдөл нь эрсдэлд орсон мэт санагдаж эхлэв.

“Би программ хангамжийн мэргэжлээр суралцаж, боловсролын зэргээ амжилттай авахын тулд . . . зээл авах боломжтой болсон. Эхнэр минь бас дуртай мэргэжлээрээ үргэлжлүүлэн сурах боломжтой болов” гэж Алфрэдо хэлсэн. Эцэст нь Алфрэдо сайн ажилд орж, Надиа шинэ боломжийн үүд хаалгыг нээсэн хүний нөөцийн чиглэлээр зэргээ эзэмшсэн юм.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Бусдад Тасралтгүй Боловсролын Сангийн талаар ярь.
- Орон нутгийнхаа сургуульд сайн дураараа ажилла.
- Хүүхдэд ном бэлэглэ.



Зүүн гар талд: EnglishConnect-ийн англи хэлний хичээлдээ оролцохоор цуглав. Баруун гар талд: Пүэрто Рикогийн сургуульд явж буй залуу эрэгтэй.



Дээрэт Индастрийс (Deseret Industries)-ийн туслах ажилтанд хандивласан эд зүйлсийг ангилахад тусалж буй ажлын дасгалжуулагч.

**Зуучилсан ажлын
байрны тоо - 5538**

**Зохион байгуулсан зайны
сургалтын тоо - 2603**

**Хувьчилж боловсруулсан
мэргэжил сургалтын
төлөвлөгөө - 3824**

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Хөдөлмөр эрхлэх боломж хайх үедээ найз нөхөдтэйгөө эсвэл гэр бүлийн гишүүнтэйгээ ярилцлагын ур чадварын дадлага хий.
- Орон нутгийн ашгийн бус байгууллагад ажил хайж буй хүмүүст зориулж зөвлөгөө өг.
- Өөрийнхөө мэддэг ажлын байрны боломжийн талаар таньдаг хүмүүстээ хуваалц.

Хөдөлмөр эрхлэлт

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжилдаг нэг арга зам нь хувь хүмүүсийг тогтмол орлоготой болох, мэргэжлээрээ өсөж хөгжих ажилд бэлтгэх, ажилд ороход нь туслах арга хэрэгсэл, үйлчилгээгээр хангах явдал юм.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээгээр ажил эрхлээгүй, ажиллах хүчинд дахин элсэж буй эсвэл одоогийн ажлын нөхцөлөө сайжруулахыг хүсэж буй хүмүүст тусалцаа үзүүлдэг. Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөхүүд төвөөс хол амьдардаг хүмүүст зориулж зайнаас тусламж үзүүлдэг ба мөн биечлэн тусламж үзүүлэх үйлчилгээгээр хангадаг.

Хөдөлмөр эрхлэлтийн тусламж нь Сүмийн гишүүдэд болон бусдад туслах олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг. Зөвлөхүүд анкет бичих зэрэг ярилцлагын ур чадвараас эхлээд холбоо тогтоох хүртэл бүх зүйлд тусалдаг идэвхтэй ажил хайх бүлгүүдийг болон ганцаарчилсан сургалтыг санал болгодог. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь хувийн бизнесээ эхлүүлэхийг зорьж буй хүмүүст зориулан сургалт, зөвлөгөө өгөх, санхүүжилтийн мэдээллээр хангах зэрэг хувиараа хөдөлмөр эрхлэх эх үүсвэрүүдийг санал болгодог.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь ажил хайх ур чадваруудыг заадаг “Мэргэжилтнээс асуу” форум, семинар, онлайн хэлэлцүүлгийг мөн санал болгодог. Эдгээр эх сурвалжийг Employment.ChurchofJesusChrist.org вэбсайтаас харах боломжтой.

Хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээ

Хөгжүүлэлтийн зөвлөхүүд нийгмийн бүхий л давхаргын хүмүүст хөдөлмөр эрхлэхэд тулгардаг саад бэрхшээлийг таньж мэдэн, даван туулахад нь тусалдаг. ДИ (Дээрэт Индастрийс)-ийн дэлгүүр бүрд үйл ажиллагаа хариуцсан ахлагчид хөгжүүлэлтийн зөвлөхүүдтэй нягт хамтран ажиллаж, туслах ажилтнуудад чанартай дэмжлэг үзүүлдэг. Хөгжүүлэлтийн зөвлөхүүд одоогоор ДИ-ийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй бусад сонгогдсон байршилд мөн ажилладаг.

Хөгжүүлэлтийн зөвлөхүүд хөдөлмөр эрхлэлт, бие даах чадварт ахиц дэвшил гаргахад туслах давуу тал, саад бэрхшээл, стратегийг тодорхойлох нарийн дүн шинжилгээ хийдэг. Түүнчлэн тэд хувь хүмүүст сэтгэл санааны хүнд байдлаа даван туулах, стрессээ удирдах, амьдралдаа эерэг өөрчлөлт гаргахад тусалдаг.

Хүмүүнлэгийн төв

ДИ дэлгүүр нь хүлээн авсан илүүдэл хувцсыг дэлхийн янз бүрийн газрын тусламж хэрэгтэй хүмүүст түгээхээр ангилдаг Хүмүүнлэгийн төв рүү илгээдэг.

Хүмүүнлэгийн төвийн туслах ажилтнууд янз бүрийн улс орны, өөр өөр гарал түүхтэй хүмүүс байдаг. Олонх нь эх орондоо болж буй зөрчилдөөн, өлсгөлөн, бусад зовлон бэрхшээлийн улмаас дайжин ирсэн байдаг. Тэдэнд ажиллаж байхад нь орлого олох, англи хэлний хичээлд хамрагдах (ажлын цагт багтаан) боломжийг олгодог.

Дээрэт Индастрийс (Deseret Industries)

2023 онд Дээрэт Индастрийс (ДИ) 85 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлжээ. ДИ нь байгуулагдсан цагаасаа хойш хөдөлмөр эрхлэхэд бэрхшээлтэй хүмүүст зориулан ажил олоход нь тусалж, илүү сайхан ирээдүйгээ бий болгоход нь дэмжлэг үзүүлсээр ирсэн. Одоогийн байдлаар Дээрэт Индастрийс нь АНУ-ын 8 мужийн 46 байршилд үйл ажиллагаагаа явуулж, ямар ч цаг үед 4000 хүртэлх тооны туслах ажилтанд үйлчилж байна.

ДИ-ийн туслах ажилтнууд дэлгүүрт ажиллаж, орон нутгийн бизнесийн түншүүдтэй сургалт хийж, жижиглэнгийн худалдааны талаар үнэ цэнтэй ажлын туршлага хуримтлуулж, ажлын дадалд суралцаж, ямар ч үйлдвэрлэлийн зах зээлд амжилт гаргах боломжийг олгодог бусад амьдралд тустай чухал ур чадваруудыг эзэмшиж байна. Уг ажлын байрны сургалтын хөтөлбөрийг үндсэн модон тавилга, унтлагын хэрэгслийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Deseret Manufacturing (Дээрэт Мануфакчуриг) байгууллагын туслах ажилтнууд мөн адил ашиглах боломжтой. Туслах ажилтнууд үйл ажиллагаа хариуцсан ахлагчтай тогтмол уулзаж, чиглүүлэг, урам зориг авдаг.

Шилжилтийн үйлчилгээ

Сүм мөн Юта, Нивада, Аризона зэрэг мужуудад Шилжилтийн үйлчилгээний есөн албатай. Эдгээр байршил дахь Шилжилтийн үйлчилгээний ажилтнууд болон сайн дурынхан нийгэмшүүлэх тусламж хэрэгтэй хүмүүст дэмжлэг үзүүлдэг. Үүнд засан хүмүүжүүлэх газраас суллагдсан хүмүүс, орон гэргүй хүмүүс эсвэл хүний наймааны хэрэгт өртсөний дараа тэнхэрч буй хүмүүс зэрэг хамрагдаж болно. Эдгээр алба нь ахмад дайчид, өөр улсаас цагаачилсан иргэдэд мөн үйлчилгээ үзүүлдэг.

Шилжилтийн үйлчилгээний ажилтнууд ийм хүмүүст зориулж хоол хүнс, хувцас, автобусны тасалбар, бусад хэрэгцээтэй зүйл зэрэг материаллаг тусалцаа үзүүлдэг. Шилжилтийн үйлчилгээ нь Хөдөлмөр эрхлэлтийн тусламж, Гэр бүлд зориулсан үйлчилгээтэй ойр ажиллаж, эдгээр хувь хүнд удаан хугацаанд бие даах чадвартай болоход нь туслах төлөвлөгөө боловсруулдаг.

Амьдралын шинэ эхлэл

Андрэ Сүмд хоёр жил номлолд үйлчилснийхээ дараа кинезиологийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалахын тулд шаргуу хөдөлмөрлөсөн. Гэвч өмнөх ослын улмаас үүссэн биеийн эрүүл мэндийн асуудал нь түүнийг жороор олгох эмд донтоход хүргэжээ. Хэсэг хугацаанд орон гэргүй амьдарсны эцэст Андрэ Шилжилтийн үйлчилгээний албанаас тусламж хүсэв.

Тус албаны ажилтан Андрэтай хамт нөхцөл байдлыг нь үнэлж дүгнээд, төлөвлөгөө боловсруулсан. Тэд хөнгөлөлттэй орон байр хайх тал дээр хэд хэдэн нийгэмлэгийн байгууллага, орон нутгийн сүмийн гишүүнтэй хамтран ажиллав. Тэд Андрэд Сүмийн донтолтоос ангижрах хөтөлбөрт хамрагдаж, ажил олоход тусалсан нь түүнд амьдралын шинэ эхлэлийг өгсөн.

“Одоо л бид бусдыг адисалж, ‘сульдсан гарыг тэнхрүүлж’ чадна.”

ЕРӨНХИЙЛӨГЧ РАССЭЛЛ М.НЭЛСОН, ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ.¹¹



Зүүн гар талд: Хөдөлмөр эрхлэлтийн төвд идэвхтэй ажил хайх бүлгийн уулзалтад оролцож буй ажил хайж буй хүмүүс. Голд: Мексик дэх ресторанд ажиллаж буй эрэгтэй. Баруун гар талд: Үйлчлэлийн залуу номлогч, ахмад номлогч Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хэлтэст үйлчлэхээр дуудагдав.

Грэйт Солт Лэйк (Great Salt Lake) нуурт хандивласан усны хувьцаа - 5700

Монголд хандивласан мод - 140000

Юта мужийн ажилтнууд олон нийтийн тээврийг ашигласнаар буруулсан зорчих километр - 1.85 сая км

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Сүмийн удирдагчид болон бусад хүн эх дэлхийгээ хайрлаж хамгаалах тухай юу заасныг олж мэд.
- Эрчим хүч хэмнэх, усны хэрэглээг багасгах, хог хаягдлыг бууруулах арга замуудыг хайж ол.
- Байгаль орчны асуудлын улмаас үүссэн ачаа дарамтыг хөнгөлөхийн тулд гамшгийн тусламж үзүүлэх ажилд сайн дураараа оролц.

“Бид хариуцлагатай иргэд байж, ухаалаг үүрэг хариуцлагын үнэ цэн, дадал хэвшилээр дамжуулан олж авснаасаа илүү сайхан дэлхийг хойч үедээ өвлүүлэн үлдээх үүрэгтэй.”

—БИШОП Л.ТОДД БАЖ,
ТЭРГҮҮЛЭХ БИШОПЫН ЗӨВЛӨЛИЙН
ХОЁРДУГААР ЗӨВЛӨХ¹²

Байгаль орчныг хамгаалах

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм эх дэлхийгээ болон байгалийн нөөцийг хамгаалах нь тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахтай нягт холбоотой гэдэгт итгэдэг. Сүм 2023 онд ус, эрчим хүчний хэмнэлт, дахин боловсруулах зэрэг төслүүдээр дамжуулан байгаль орчноо хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Мөн Сүм аль болох орон нутгийн нөөц, түүхий эдийг ашиглах байдлаар хүмүүнлэгийн төслүүдийг хэрэгжүүлэх тогтвортой шийдлүүдийг эн тэргүүнд тавьдаг.

Усны хэмнэлт

Сүм 2023 онд Сүмийн олон байгууламжид ашигладаг Сүмийн бүх хөдөө аж ахуйн өмч хөрөнгө, суурилуулсан ухаалаг хянагч, гидрометр, борооны ус мэдрэгч, дулаар услах усалгааны системд зориулан усны менежментийн төлөвлөгөөг хөгжүүлэхэд анхаарсан. Уг ажилд ган гачигт өртөмтгий бүсүүдэд тогтвортой ландшафтын зарчим, ус хэмнэх аргуудыг туршихын тулд хэд хэдэн цуглааны байруудын ландшафтыг шинэчилсэн зэрэг багтана.

Сүм 2023 оны 3-р сард ган гачиг ихтэй бүс болох Юта мужийн Грэйт Солт Лэйк нуурт жил тутмын усалгааны ус болох 24.6 тэрбум литр ус хандивласан. Тус хандив нь урьд өмнө хэзээ ч мужид хандивлаж байгаагүй ашиг тусаа өгөх хамгийн том байнгын хандивын нэг болсон бөгөөд энэ нь 20000 гаруй айлын байнгын усан хангамжтай тэнцэхүйц юм. Уг ус нь үргэлжлүүлэн тус нуурт цутгах ба нуурын хүрээлэн буй орчныг хадгалж үлдэхэд туслах юм.

Эрчим хүчний хэмнэлт

Байгалийн нөөц хариуцагчдын хувьд Сүм санхүүжилт, байгалийн нөөцийг маш хянуур удирддаг. 2023 онд хэрэгжүүлсэн эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэх ажлын дунд Сүм дэлхий даяарх олон цуглааны байранд нарны хавтан суурилуулсан.

Дахин боловсруулалт

Сүм 2023 онд 100% дахин боловсруулсан хуванцар аягыг ариун ёслолд ашиглаж эхэлсэн. Түүнчлэн Дээрэт Индастрийс (Deseret Industries) нь хогийн цэгт хүргэгдэж болзошгүй байсан хандивласан эд зүйлсийг хүлээн авч, тэдгээрийг зориулалтын дагуу ашиглаж, зарим тохиолдолд дахин боловсруулснаар чухал үүрэг гүйцэтгэж байна.



Зүүн гар талд: Японд хүүхдүүдтэйгээ хамт дугуй унаж буй ээж. Голд: Сүмийн үйлчлэлийн залуу номлогч Огдэн ариун сүмийн эргэн тойронд цэцэг тарьж байна. Баруун гар талд: Грэйт Солт Лэйкийн хуурай газар дээрх боомт.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөдөлгөөний бэрхшээлд дэмжлэг үзүүлэх

Христ мөнх бус тохинууллынхаа үеэр бие махбодын тусгай хэрэгцээтэй, сул дорой, өвчин эмгэгтэй хүмүүст тохинуулахад онцгой анхаарал халамж тавьсан. Есүс Христийн Сүм эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөдөлгөөний бэрхшээлд дэмжлэг үзүүлэх дэлхий даяар өрнүүлсэн ажлаараа дамжуулан энэхүү зорилгыг өнөө үед үргэлжлүүлж байна.

Дархлаажуулалт

Сүм дэлхий даяарх вакцинжуулалтын ажилд идэвхтэй оролцдог. АНУ дахь НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтарч Сүмээс дэмжсэн ажил болох Замби улсад вакцинжуулалтыг нэмэгдүүлэх санаачилгыг хэрэгжүүлсэн нь үүний нэг тод жишээ юм. Тус санаачилгын хүрээнд орон нутгийн Эрүүл Мэндийн Яам, АНУ дахь НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтарч, улаан бурхан, халдварт саа өвчний эсрэг дархлаажуулалтыг хувь хүмүүст илүү хялбар хүртээмжтэй болгосноор бүс нутаг дахь халдварын дэгдэлтийн тоог бууруулсан. Сүмийн санхүүжүүлэлтээр Афганистан, Пакистан улсуудад вакцинжуулалтын эмч нарыг сургах НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилд болон улаан бурхан, халдварт саа өвчний өвчний эсрэг хүүхдүүдийг дархлаажуулах Перу дэх Эрүүл Мэндийн Яамны аянд мөн дэмжлэг үзүүлсэн.

Барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэх

Сайжруулсан эмнэлгийн байгууламж нь эмч, сувилагч нарт олон нийтийн эрүүл мэндийг цогцоор нь сайжруулахад туслах илүү чанартай тусламж үзүүлэх боломжийг олгодог. Сүмийн 2023 онд хэрэгжүүлсэн бусад ажлын дотор Бүгд Найрамдах Палау Улсын эмнэлэгт био анагаах ухааны хэрэгслүүдийг хандивласан ба Оросын Холбооны Улсын Брянск бүс нутгийн эмнэлгийг шинэчлэхэд туслах зорилгоор ханган нийлүүлсэн эмнэлгийн хангамж, санхүүжилтийн төсөл орно. Сүм түүнчлэн Зимбабве улсад хөдөө орон нутгийн эрүүл мэндийн клиник шинээр барьж, дуусгасан ба ор, бусад эмнэлгийн үндсэн тоног төхөөрөмжийг хандивласан. Сүм энэ төслийн нэгээхэн хэсэг болгон эмнэлгийн ажилтнуудын орон байрыг сайжруулах, байгууламжуудыг нарны эрчим хүчээр хангах, усны эх үүсвэр болох гүний худаг гаргахад тусалсан.

Хараа зүйн тусламж

Хараа зүйн тусламж нь 2023 онд хүмүүнлэгийн төслийн тэргүүлэх чиглэл хэвээр байв. Сүм катаракт нүдний эмгэг эмчлэх, хараа зүйн тусламжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад зориулсан төслүүдийг дэлхий даяар санхүүжүүлэхэд тусалсан. Жишээлбэл: Сүм Мозамбик улсын алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд нүдний үзлэг, эрүүл мэндийн эмчилгээг санал болгосон. 2023 онд хэрэгжүүлсэн бусад төслөөс гадна Малайз улсад катарактын хагалгаа хийхэд ашиглагдах 500 ширхэг нүдний дотоод линз хандивласан ба Перу улсад олон мянган хос нүдний шил, Мексикийн Чиapasын нүдний үзлэгийн чанарыг сайжруулахад туслах автомат рефрактор кератометрийг Сүм хандивлажээ.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Хэрэглээгүй таяг, хөдөлгөөний бэрхшээлд дэмжлэг үзүүлэх бусад хэрэгслийг орон нутгийнхаа эмнэлэгт хандивла.
- Вакцины ач холбогдлын талаар судалж, мэддэг зүйлсээ найз нөхөд, хөршүүддээ хуваалц.
- Орон нутгийн хараа зүйн үзлэг, бусад эрүүл мэндийн арга хэмжээг зохион байгуулахад сайн дураараа оролц.

Хандивласан тэргэнцэр - 25786

Хараа зүйн төсөл - 29

Эх, нярайн асаргааны төсөл - 73

Хондурас улсад тэргэнцрээр хандивласан нь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хандивын тусламжтайгаар Сан Пэдро Сула дахь хөдөлгөөний бэрхшээлтэй олон зуун хүүхэд, насанд хүрсэн хүн тэргэнцэр, биеийн байрлал дэмжих төхөөрөмжийг хүлээн авсан. Үүний үр дүнд тэд одоо илүү их бие даасан байдал, хүндлэл бахдалыг мэдэрдэг.

Сүмийн 2023 онд хэрэгжүүлсэн хэд хэдэн хандивын зөвхөн нэг нь л гэхэд дэлхий даяар олон мянган хүнд нөлөөлж байна.



Замби улсад эрүүл мэндийн ажилтан нярайд халдварт саа өвчний эсрэг вакцин хийж байна. Гэрэл зураг, ©НҮБ-ын Хүүхдийн Сан/UN0663888/Шэрмбракэр.



Зүүн гар талд: Хаитид сургуулийн тэжээллэг хоол идэж буй хүүхэд. © WFP/Тэрза Пиорр. Баруун гар талд: Сүмийн эзэмидэг фермийн аж ахуйд жимс түүж буй ахмад номлогч.

**Хүнсний аюулгүй
байдлын төсөл - 530**

Хоол тэжээлийн төсөл - 71

Төсөл хэрэгжүүлсэн улс - 94

“Есүс хүүхдүүдэд өр нимгэн сэтгэлээр ханддаг. Тэр тэднийг өлссөн байхыг хараад нулимс нь дусалдаг. Мөн Тэрээр тэдэнд туслах гэсэн хамгийн өчүүхэн хүчин чармайлтад ч баясдаг.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ КАМИЛЛ Н.ЖОНСОН,
ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ
ЕРӨНХИЙЛӨГЧ¹³

ӨЛСГӨЛӨНТЭЙ ТЭМЦЭХ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бие даах чадварын зарчмуудыг хэрэгжүүлж, бусдад мөн адил зүйлийг хийхэд нь туслахыг хичээдэг. Өлсгөлөн, бусад яаралтай шийдвэрлэх материаллаг хэрэгцээтэй тэмцэж буй олон хүний хувьд үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй тохиолдолд удаан хугацааны бие даах чадварт анхаарлаа хандуулах нь бэрх байдаг. Сүм өлсгөлөнгийн хэрэгцээг нэн даруй шийдвэрлэх, чанартай хоол тэжээл, урт хугацааны хүнсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх байдлаар эдгээр хувь хүнд туслахыг эрэлхийлдэг.

Нэн даруй шийдвэрлэх шаардлагатай хэрэгцээг зохицуулах

Өлсгөлөнгийн хэрэгцээг яаралтай шийдвэрлэхэд туслахын тулд Сүм 123 бишопын агуулахыг ажиллуулдаг ба ингэснээр орон нутгийн Сүмийн удирдагчид цуглааныхаа гишүүдийн хүнс, бусад зүйлийг үнэгүй хүлээн авах ажлыг зохион байгуулах боломжтой. Түүнчлэн эдгээр агуулах нь олон зуун орон нутгийн хүнс хандивлах санд бүтээгдэхүүн хандивладаг. Бишопын агуулахад хүргэгддэг бүх барааны нийт хэмжээний дөрөвний гурав нь Сүмийн фермийн аж ахуй, жимсний цэцэрлэг, мал аж ахуйн үйл ажиллагаа, боловсруулах үйлдвэрүүдээс ирдэг үйлдвэрлэсэн ба/эсвэл боловсруулсан бүтээгдэхүүнүүд байдаг. Эдгээр үйл ажиллагаанд Сүмийн болон нийгмийн гишүүд мөн үндэсний байгууллагын сайн дурынхан зэрэг сайн дурын ажилтнууд дэмжлэг үзүүлдэг. Бишопын агуулахгүй байршлуудад удирдагчид тусламж хэрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд орон нутгийн хүнсний дэлгүүрүүдээр зохицуулдаг. Сүм дэлхий даяарх өлсгөлөнтэй голчлон тэмцдэг байгууллагуудад мөн дэмжлэг үзүүлдэг. Үүнээс гадна Сүмийн гишүүд нийгмийнхээ хэрэгцээг хангахад туслах хоол хүнс цуглуулдаг компаниг арга хэмжээнд тогтмол оролцдог.

Хоол тэжээл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хоол тэжээлийн дутлыг бууруулахыг зорьдог ба орон нутгийн байгууллагуудад анхан шатны арга хэмжээг зохион байгуулах тал дээр онцгой байр суурь эзэлдэг.

2023 онд Сүмээс үргэлжлүүлэн дэмждэг хүүхдийн хоол тэжээлийн аянд хоол тэжээлийн дуталд орсон Сүмийн гишүүдийн хүүхдүүдийг дэмждэг Сүмийн Халамжийн нийгэмлэгийн удирдсан санаачилга багтдаг. Энэхүү санаачилгаар дамжуулан орон нутгийн Сүмийн удирдагч, гишүүд хоол тэжээлийн дутлын нийтлэг шинж тэмдгийг танин мэдэх, хоол тэжээлийн байдлын үзлэгийг хэрхэн хийх талаар сургалт авдаг. Уг санаачилга нь Сүмийн гишүүдэд орон нутгийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хоол тэжээлийн нэмэлт, дархлаажуулалт зэрэг бусад тусламжийг хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлснээр хоол тэжээлийн дуталд орох эрсдэлийг бууруулахад мөн тусалдаг.

Сүм хүмүүнлэгийн ажлынхаа нэг хэсэг болгон хөдөө орон нутаг дахь тариаланчдад үндсэн дэмжлэг үзүүлсэн ба орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн системтэй хамтран боловсролыг дээшлүүлэх, эмчилгээний хоолыг хүртээмжтэй болгох тал дээр ажилласан. Сүм нь КЭЙР (CARE), Хэлэн Кэллэр Интернэйшнл (Helen Keller International), Католик Релиф Сэрвисэс (Catholic Relief Services), Хүүхдийг Ивээх Сан, Ай Ди И (iDE), Хангэр Прожэкт (the Hunger Project), НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн хүнсний хөтөлбөр зэрэг мэргэшсэн байгууллагуудтай хамтран ажилласнаар өндөр эрсдэлд өртсөн өөр өөр гарал түүхтэй гэр бүлүүдийг эгзэгтэй цаг үед хэрэгтэй нэмэлт хоол тэжээлийн эх үүсвэрээр хангах, дөнгөж нярайлсан эх, хүүхдэд өсөж бойжиход шаардлагатай хоол тэжээл авах хүртээмжийг бий болгоход тусалсан.

Хүнсний аюулгүй байдал

Дэлхий дахиныг хамарсан хүнсний аюулгүй байдал нь 2023 оны хүмүүнлэгийн төслийн тэргүүлэх чиглэл хэвээр байв. Сенегал улсын Май Агро (MyAgro) байгууллагад бордоо зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд худалдан авахад тусалж, олон мянган тариаланчид сургалт өгөн, урт хугацааны хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг дэмжихэд туслалцаа үзүүлсэн. Сүм түүнчлэн Замбигийн Ай Ди И (iDE) байгууллагатай хамтран олон мянган тариаланчид зориулсан түүхий эд, зах зээлийг хүртээмжтэй болгох ажлыг сайжруулж, бүс нутаг дотроо орлогоо нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэв.

Сүм мөн хотын болон гэр бүлийн хүнсний ногооны талбайгаар дамжуулан хүнсний аюулгүй байдлыг сайжруулах хэд хэдэн төсөлд дэмжлэг үзүүлсэн. Жишээлбэл: Филиппин улсад сүм Хөдөө аж ахуйн хэлтэс, Ургамлын үйлдвэрлэлийн товчоотой нэг баг болж ажиллан, Сан Хуан хотод хотын хөдөө аж ахуйн төслийг эхлүүлсэн. Уг төсөл нь иргэдэд ногоо тариалж, улмаар гаднын хүнсний эх үүсвэрээс хамаарах хамаарлыг бууруулснаар хотын тогтвортой фермийн аж ахуйн технологийг хэрэгжүүлж, дэмжихэд тусалдаг.

Хоол хүнсний хүртээмж нь бие даах чадварыг нэмэгдүүлдэг

2023 онд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Хангэр Прожэкт (The Hunger Project)-тэй хамтран ажиллаж, Буркина Фасогийн орон нутгийн иргэдэд зориулан үр тариа тээрэмдэх зэрэг хамтдаа цугларч, эх үүсвэрээ хуваалцах боломжтой төвийг байгуулсан.

Уг төсөл нь тосгоныхоо ганц тээрмийг ашиглахын тулд хол зайд алхаж, урт эгнээнд дугаарладаг байсан дөрвөн хүүхдийн эх Хинминд бодитоор нөлөөлсөн юм. Харин одоо тэрээр тээрэмд бага цаг, мөнгө зарцуулж, гурилаа хурдан авдаг болсноор орлого олох, хүүхдүүдээ дэмжих цаг завтай болсон.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон нутгийн хүнсний нөөцийн зооринд хандив өргөж, сайн дурын ажил хий.
- Амьдардаг газартаа өлсгөлөнгийн хэрэгцээг шийдвэрлэх олон нийтийн хүнсний ногооны цэцэрлэг байгуул.
- Найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ нийгэмд тохиолдож буй өлсгөлөн, үүнд тэд туслахын тулд юу хийж болох талаар ярилц.



Тайван дахь хүнсний ногооны цэцэрлэгт ажиллаж буй гэр бүлийн хос.

Орон гэргүй хүмүүст
зориулсан төсөл - 374

Шилжилтийн үйлчилгээний
эх үүсвэрийг ашигласан
хувь хүмүүсийн тоо - 11063

Шинэ улсад амьдралаа дахин эхлүүлэх

Надиа гэр бүлийнхэнтэйгээ 2023 онд Америкийн Нэгдсэн Улс руу нүүжээ. Надиа болон түүний нөхөр хоёр өндөр боловсролтой байсан хэдий ч эрүүл мэндийн асуудлын улмаас шинэ газарт ажил олоход хүндрэлтэй байв.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн болон Лао Фэмили Коммюнити Дэвэллопмент (Lao Family Community Development) байгууллагын тусламжтайгаар Надиа, түүний нөхөр хоёр орон гэргүй болохоос зайлсхийх, байрны хөлсөө төлөх санхүүгийн дэмжлэг хүлээн авах боломжтой болов. Цагаа олсон энэхүү тусламжийн ачаар Надиа нөхөртэйгөө хоёул илүү бие даасан чадварт хөтлөх ажил хайж олох дээр төвлөрөх боломжтой болсон.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон нутгийнхаа нүүлгэн шилжүүлэх төв, харьяа Улаан загалмай эсвэл Улаан хавирган сар нийгэмлэгт сайн дурын ажил хий.
- Амьдардаг газартаа хоргодох байр хайж буй гэр бүлийг ивээн тэтгэ
- Нийгмийнхээ орон гэргүй болсон хүмүүсийн хэрэгцээний талаар хөршүүдтэйгээ ярилц.

Орон байрны дэмжлэг

Хүмүүсийн орон гэргүй болсон нь олон шалтгаантай байдаг. Орон гэргүй байх нь байгалийн гамшиг, зөрчилдөөнөөс эсвэл өөр нэгэн ноцтой нөхцөл байдлаас болж үүссэн түр зуурын нөхцөл байдал байж болно. Зарим тохиолдолд ажлаа алдах, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, донтолтоос эсвэл зүгээр л хэцүү нөхцөл байдал орсноос үүдэн орон гэргүй болж болно. Ямар ч шалтгаантай байсан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хүн бүрийн хувийн эрх, аюулгүй байдал, нэр хүндэд нөлөөлдөг орон байрны асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн томоохон хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг.

Орон гэргүй хүмүүст туслах

Сүм Америкийн Нэгдсэн Улсад Шилжилтийн үйлчилгээний есөн алба ажиллуулдаг. Эдгээр албаны ажилтнууд орон гэргүй хүмүүст нөхцөл байдлаа өөрчлөхийг эрэлхийлж байхдаа хайр халамж, дэмжлэг мэдрэхэд нь туслахаар бэлтгэгдсэн байдаг. Шилжилтийн үйлчилгээ нь яаралтай шийдвэрлэх материаллаг хэрэгцээнд тусалж, хувь хүмүүст орон нутгийн нийгэмлэгийн эх үүсвэрүүдийг санал болгож, сэтгэцийн эрүүл мэнд, донтолт, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээнд нь тусламж үзүүлдэг. Сүм Америкийн Нэгдсэн Улсын өөр өөр газарт болон дэлхий даяар орон гэргүй болсон хүмүүст үйлчилдэг байгууллагуудыг дэмжихээр хүмүүнлэгийн санхүүжилт, хандивын тусламж үзүүлдэг.

Яаралтай орогнох байр

Сүм 2023 онд хэрэгжүүлсэн бусад ажлын дунд Шэлтэрбокс (ShelterBox)-той хамтран Йеменд болсон зөрчилдөөний улмаас нүүлгэн шилжүүлэгдсэн олон мянган гэр бүлд майхан хандивлажээ. Сүм түүнчлэн цуглааны байрыг түр зуурын орогнох байр болгон нээж, Мауид болсон ой хээрийн гал түймрийн улмаас нүүлгэн шилжүүлэгдсэн оршин суугчдад зочид буудлын эрхийн бичиг олгов.

Эмзэг бүлэгт туслах

Сүм орон гэргүй болох эрсдэл өндөртэй эмзэг бүлгийн иргэдэд (хоргодох эсвэл орогнох байр хайж байгаа хүмүүст) туслахаар хэд хэдэн байгууллагатай хамтран ажилласан. Жишээлбэл: Сүм олон мянган хүнд орогнох байр, хувцас хунар, хууль эрх зүйн туслалцаа авах зэрэг олон дэмжлэг үзүүлэхэд тусалж, арван нэгэн орогнох байр, олон нийтэд үйлчлэх дөрвөн гал тогоонд тоног төхөөрөмж хандивлан, Пасторал Димэншн оф Хюман Мобилити оф дэ Конфрэнс оф дэ Мексикан Эпископат (Pastoral Dimension of Human Mobility of the Conference of the Mexican Episcopate) байгууллагатай хамтран ажиллажээ.



Зүүн гар талд: Сирид нүүлгэн шилжүүлэгдсэн гэр бүл орогнох байрны иж бүрдэл, бусад хэрэгцээтэй зүйлийг хүлээн авч байна. АНУ дахь Шэлтэрбокс (ShelterBox USA)-ын гэрэл зураг. Баруун гар талд: Калифорниад орон нутгийн сайн дурын ажилтнууд орон гэргүй хүмүүст зориулсан орогнох байранд ор бэлтгэхэд тусалж байна.

Сэтгэцийн эрүүл мэнд

Сэтгэцийн болон сэтгэл санааны асуудал хүмүүсийн бусадтай холбоо тогтоох, эргэн тойрондоо бүрэн хувь нэмрээ оруулах чадварыг нь хязгаарласан мэдрэмжтэй байх шалтгаан болдог. Тэд эдгээр асуудлыг даван туулах эмчилгээг эрэлхийлснээр илүү баяр баясгалан, сэтгэл ханамж мэдэрч, сэтгэлийн тэнхээтэй болж сурдаг.

Сэтгэцийн болон сэтгэл санааны асуудалтай тулгарч буй Сүмийн гишүүд бишопынхоо санал болгосны дагуу Гэр бүлд зориулсан үйлчилгээгээр дамжуулан тусламж, эх сурвалжуудыг үнэ төлбөргүй авах боломжтой. Гэр бүлд зориулсан үйлчилгээ нь түүнчлэн тусламж хэрэгтэй гишүүдэд тохинуулах Сүмийн удирдагчдын ажлыг дэмжихийн тулд тэдэнд зориулсан зөвлөгөөг өгдөг. Зөвлөгөөг Сүмийн номлогчид, хүүхэдтэй болох гэж буй эцэг/эх, гэр бүл, гэр бүлийн хос, хувь хүмүүс авах боломжтой.

Гэр бүлд зориулсан үйлчилгээний санал болгодог нэг эх сурвалж нь *Аврагчаар дамжуулан эдгэрэх нь: Донтолтоос ангижрах хөтөлбөр* юм. Тус хөтөлбөр нь хянахад хэцүү зан авиртайгаа тэмцэж буй Сүмийн гишүүдэд болон бусад хүнд дэмжлэг үзүүлэн, гэр бүлийн гишүүдэд нь дэмжлэг үзүүлэх бүлгүүдийг санал болгодог. Сүм түүнчлэн амьдралын саад бэрхшээлийг сөрөн зогсох чадваруудад суралцахад оролцогчдод туслах *Их Эзэнээр дамжуулан хүч чадал олж авах нь: Сэтгэлийн тэнхээтэй байх* гэсэн бие даах чадвар хөгжүүлэх бүлгийг санал болгодог.

Түүнчлэн, Гэр бүлд зориулсан үйлчилгээ нь хямралын үед сэтгэл санааны тусламж үзүүлдэг. Жишээлбэл: 2023 онд аймшигт ой хээрийн гал түймэрт өртсөн Сүмийн гишүүдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэхээр Хавайн Мауи арал руу мэргэжлийн зөвлөх багийг томилсон.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Христийнхтэй адил хайр, эелдэг байдлыг хөршүүддээ үзүүл. Учир нь тэднийг юу туулж байгааг та хэзээ ч мэдэхгүй.
- Амьдардаг газрынхаа донтолтоос ангижрах хөтөлбөр, Сэтгэлийн тэнхээтэй байх нь бүлгүүдийг дэмж.
- “Асуу, ятга, лавла” гэсэн сургалтад хамрагдаж, эргэн тойрныхоо амиа хорлох бодолтой байж магадгүй хүмүүсийг хэрхэн дэмжих талаар мэдэж ав.

Зөвлөх үйлчилгээний
цаг - 218170

Гэр бүлд зориулсан үйлчилгээ
хэрэгжсэн улсын тоо - 97

Долоо хоног тутмын донтолтоос
ангижрах бүлгийн уулзалт - 2926

Дахин итгэл найдвар олох

Европт Гэр бүлд зориулсан үйлчилгээгээр бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст зориулан дэмжлэг үзүүлэх бүлгийг байгуулсан гэдгийг сонссон Лүсид* дахин итгэл найдвар төрж, тэрхүү хамт олны нэг гэдгээ мэдэрчээ. Сүм ийм бүлгүүдийг санал болгодог ба эдгээрийг бэлтгэгдсэн зөвлөхүүд удирддаг.

Үүнд хамрагдсанаар Лүси өөртөө тохиолдсон явдлыг сэтгэл зүй, сэтгэл санаа, сүнслэг байдалд нь нөлөөлсөн гэдгийг ойлгож эхэлжээ. “Би олон жилийн өмнө итгэл найдвараа алдсан, харин одоо надад эргээд итгэл найдвар төрж байна” гэж Лүси хэллээ.

*нэрийг өөрчлөв

“Бид сэтгэл санаа, бие махбодын болон сүнслэг тусламжийг эргэн тойрныхоо хүмүүст үзүүлэх боломжтой байгаа нь . . . үнэхээр гайхалтай адислал юм.”

—Ж.АНЭТТ ДЭННИС ЭГЧ,
ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ¹⁴



Зүүн гар талд: Байгалийн үзэмжийг найзуудтайгаа бишрэн, инээмсэглэж буй залуу эмэгтэй. Голд: Донтолтоос ангижрах бүлгийн уулзалт. Баруун гар талд: Сүмийн гишүүд Сэтгэлийн тэнхээтэй байх нь хичээлийг удирдаж мөн оролцож байна.

Бие даах чадвар хөгжүүлэх

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бие даах чадвартай байх гэдэгт итгэдэг. Бид өөрсдөө анхаарал халамж тавих чадвартай болсноор Бурханаа хайрла, хөршөө хайрла гэсэн Аврагчийн өгсөн хоёр агуу тушаалд илүү сайн төвлөрч чадна.

Бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүд

Сүм гишүүдэд бие даах чадвар хөгжүүлэхэд туслах хэд хэдэн бүлгийг санал болгодог. Оролцогчид хэрхэн бизнесээ эхлүүлэх, санхүүгээ зохицуулах, ажил олох зэргээс гадна илүү олон зүйлд суралцаж болно. Үр нөлөө нь чухал ач холбогдолтой байх болно.

Жишээлбэл: Освалдо хүүхэд байхдаа аймшигт ослын үеэр хоёр гаргүй болжээ. Тэрээр бие даах чадвартай болохыг хүссэн тул өөрийн төрсөн газар болох Парагвайд Сүмийн хэд хэдэн бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт хамрагдав. Эдгээр бүлэгт тэрээр хувийн санхүү, ажил хайх ур чадвар мөн хэрхэн сэтгэлийн тэнхээтэй байх талаар сурсан. Үүний үр дүнд тэрээр телемаркетингийн ажилд орох боломжтой болсон бөгөөд дараа нь өөрийн гэсэн хэвлэх, гэрэл зургийн бизнесийг эхлүүлжээ.

Хүмүүнлэгийн ажил

Сүм тоо томшгүй хүмүүнлэгийн ажлаараа дамжуулан нэн даруй шийдвэрлэх шаардлагатай хэрэгцээнд тусламж үзүүлэхийн сацуу хувь хүмүүсийг удаан хугацааны бие даахад хөтлөх зорилгыг үргэлж тээдэг.

Жишээлбэл: Сүм Өмнөд Дакота дахь Сиссетон-Вопетон Ояатэ (Sisseton-Wahpeton Oyate) омгийнхонд өөрсдийгөө тэтгэх нэмэлт хэрэгслээр хангахын тулд хүнс боловсруулах тоног төхөөрөмж хандивласан. Сүм түүнчлэн Америкийн Нэгдсэн Улс даяарх боловсрол эзэмшсэн цагаачдад зориулж эмч, шүдний эмч, багш зэрэг бусад мэргэжлийн дагуу ажиллах зөвшөөрөл авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Апвардли Глобал (Upwardly Global) ашгийн бус байгууллагатай хамтран ажилласан.



Өмнөд Африк дахь бие даах чадвар хөгжүүлэх бүлэг хамтдаа уулзав.

Удирдсан бие даах чадвар хөгжүүлэх бүлгийн тоо - 14643

Бүлгийг дүүргэсэн оролцогчдын тоо - 110019

Хамрагдсан оролцогчдын улсын тоо - 90

Шинэ ур чадвараар дамжуулан бие даах чадвараа хөгжүүлэх

Эйми донтолттойгоо тэмцэхэд өсвөр насаа өнгөрөөснийхөө дараа нэрээ нууцалсан архинд донтсон хүмүүсийн уулзалтад хамрагдаж эхлэн, эрүүл байх тал дээр ажилласан. Гэвч тэрээр намтраасаа болж хүүхдүүдээ тэжээхүйц ажилд ороход бэрх байв.

Ингээд тэрээр тусламж хэрэгтэй хүмүүст илүү бие даах чадвартай болоход туслах зорилготой Позпэрити (Pawsperty) нохой арчилгааны ашгийн бус сургуулийн тухай олж мэджээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн үзүүлсэн хандивын тусламжтайгаар Pawsperty сургууль туслалцаа үзүүлдэг оюутнуудынхаа тоог гурав дахин өсгөх боломжтой болсон. Эйми энэ хөтөлбөрт элсэх боломжтой болсон бөгөөд зөвхөн тэжээвэр амьтныг арчлах ур чадварт суралцсан төдийгүй ухамсарласан хандлага, өөрийгөө танин мэдэх, харилцааны зэрэг амьдралын ур чадварт суралцжээ.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Амьдардаг газрынхаа бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт элс.
- Нийгэмдээ хичээл заах байдлаар өөрийн ур чадварыг хуваалц.
- Бусдыг бие даах чадвараа хөгжүүлэхэд тусалдаг төсөлд сайн дураараа оролц.



Мауид болсон ой хээрийн гал түймрийн дараа орон нутгийн хоёр иргэн тэврэлдэж буй нь.

Дэлхий даяар үзүүлсэн тусламж

“Дэлхийн хүнсний хөтөлбөр ба Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхийн өнцөг булан бүрийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүст хоол хүнс, бусад нэн чухал туслалцааг үзүүлэх зорилгоор 10 гаруй жил хамтран зүтгэсэн. Урьд өмнө үзэгдээгүй дэлхийн хэрэгцээ бүхий энэ цаг үед өлсгөлөнд нэрвэгдэж буй сая сая хүнд амьдралын арга зам зааж, илүү сайхан ирээдүйд итгэх найдвар өгдөг Сүмийн дэмжлэгийн төлөө бид талархаж байна.

—БЭРРОН СЭГАР, АНУ-ЫН ДЭЛХИЙН ХУНСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ганад нэгэн эмэгтэй катаракт нүдний эмгэгийн хагалгааны дараа харааны бэлэг хүлээн авлаа. Дэйбрейк Вишн Прожэкт (Daybreak Vision Project)-ийн гэрэл зураг.

Хүмүүнлэгийн төсөл - 572

Цэвэр ус, эрүүл ахуй, ус
цэвэрлэгээний төсөл - 57

Хүнсний аюулгүй байдал/
хоол тэжээлийн төсөл - 131

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон нутгийн цэцэрлэгжүүлэх төсөлд оролц.
- Харьяа газрынхаа сургуультай хамтран одоогийн хэрэгцээний талаар ярилц.
- Нярайн асаргааны талаар мэддэг зүйлээ хэн нэгэнд заа (эсвэл хувиараа илүү ихийг сур).

“Сүмийн түншлэл . . . хэнийг ч орхигдуулахгүй байхад анхааран, амьдралыг өөрчилж байна.”

—ЭВЭЛИН МЭРЭ,
НИГЕРИЙН ВАТЭР-ЭЙД (WATERAID),
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЗАХИРАЛ,

Африкт

2023 онд Сүм Африк даяар хүнсний аюулгүй байдал, цэвэр усны хүртээмж, ус цэвэрлэх байгууламж, боловсрол, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, ядуурал бууруулахын төлөө ажилласан. Уг ажил нь үйлчилсэн нийгэмдээ илүү бат бөх суурийг барьдаг бөгөөд хүний үндсэн хэрэгцээг хангах, хүний ёс зүйг хадгалж үлдэх гэсэн Сүмийн үүргийг тусгадаг.

Хоол хүнс, цэвэр усны хүртээмж

Кени улсад Сүм хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн чанарыг дээшлүүлэх, тогтвортой амьжиргааг дэмжих, ашиг тус хүртэж буй хүмүүсийг санхүүгийн гэнэтийн байдалд бэлтгэлтэй байхад сургах, боловсролыг дэмжихийг зорьдог БОМА (WOMA) ашгийн бус байгууллагатай хамтран ажилласан. Харьяа газартаа тарьж ургуулсан хүнсний ногооны эх үүсвэрийг ашиглан, “гал тогооны хүнсний ногооны цэцэрлэг” бий болгох сургалтад 1000 гаруй оролцогч хамрагдсан. Үүний үр дүнд 204 хүнсний ногооны цэцэрлэг өрхүүдийг шим тэжээлтэй хүнсээр хангаж байна.

Эсватинигийн Хоход Сүм Ватэр-Эйд (WaterAid) байгууллагатай хамтран ажиллаж, тус орон нутгийн 1200 гаруй хүнд цэвэр ус түгээв. Уг төсөлд гидрогеологийн судалгаа багтсан ба барилга байгууламж, ажиллах хүчин,



Эх, хүүхэд хоёр Кени дэх дүрвэгсдийн хуаранд орогнох байртай болж, тэжээллэг хоол хүнс хүлээн авч буй нь.



Зүүн гар талд: Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Камилл Н.Жонсон эгч, Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Х.Кордон эгч нарын Африкт хийсэн тохинууллынх нь үеэр захын лангуугаа танилцуулж буй эмэгтэй. Баруун гар талд: Мадагаскарын нэгэн ээж охиныхоо гар дээр цэвэр ус гоожуулж байгаа нь.

машин механизмаар хангаж, үр дүнд нь нарны эрчим хүчээр ажилладаг усны системийг бий болгосон.

Боловсрол

Кени улсын Нгарэмара алслагдсан тосгонд Сүм БОМА байгууллагатай хамтран орон нутгийн эмэгтэйчүүдэд гэж бүлээ тэтгэх тогтвортой орлогын эх үүсвэрийн дэмжлэг үзүүлэх, нийгэмд эзлэх байр сууриа дээшлүүлэх арга замыг заасан бизнес эрхлэх сургалт зохион байгуулав. Тус эмэгтэйчүүд заан чиглүүлэх зөвлөгөө, сургалтаар дамжуулан зах зээл дээр бүтээгдэхүүний өртгийг хэрхэн ойлгох талаар сурсан. Тухайлбал: Тэд их тоо хэмжээгээр хангамж худалдаж авах нь байнгын тээврийн зардлыг бууруулж, улмаар ашгийг нэмэгдүүлдэг гэдгийг сурсан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба тусгай хэрэгцээ

Сүм Нигерийн Абужа дахь Холбооны эрүүл мэндийн төвд диализийн аппарат, сандал, нярайн инкубатор, нярайн ор, эмнэлгийн ор, өвчтөн хянах монитор зэрэг эмнэлгийн тоног төхөөрөмж хандивласан. Сүм мөн диализийн аппаратыг цэвэр усаар хангах урвуу осмосис систем барихад тусалжээ.

Түүнчлэн Сүм эх, нярайн асаргааг эн тэргүүнд тавьж, нярайн сэргээн амьдруулах явцын бодит дадлага хийх болон бусад ур чадварын сургалтаар хангахын тулд Нигерийн Энугу дахь орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилласан. Мөн Сүм НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Танзани, Кени, Этиоп улсуудад эх, нярайн асаргааны чанарыг нэмэгдүүлэхийн тулд сургалтын төв байгуулж, хамтын зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулсан

Зимбабве улсын Хараре хотоос гадна сайн дурын ажилтнууд угаалгын өрөө, усанд орох өрөөтэй шинэ клиникийн барилгын ажлыг дуусгав. Сүмийн боловсон хүчин орон нутгийн Эрүүл Мэндийн Яамтай хамтран эмнэлгийн ажилтнуудын орон байрыг сайжруулах, нарны эрчим хүчээр ажилладаг цооногоор дамжуулан цэвэр усаар хангасан. Рвизи дэх 3500 гаруй нийгмийн гишүүн энэ ажлын үр шимийг хүртэв.

Нэг хүнийг биш харин олныг адисалсан

Рафаэл бол сонгино тариалахдаа ургамлын өвчин, хортон шавж зэрэг байнга асуудал тулгарч, бага ургац хураадаг хүндрэлтэй тэмцэж буй Замби дахь тариаланч юм. Замби дахь Ай Ди И (International Development Enterprises) байгууллагаар дамжуулан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн дэмжлэгээр Рафаэл сонгино, өөр бусад ашигтай ургамлын гарцыг нэмэгдүүлэх тогтвортой хөгжлийн технологийн талаар сургалт авах боломжтой болжээ. Ай-Ди-И байгууллага мөн сонгинын үр өгч, түүний тариалангийн талбайд дуслын усалгааны иж бүрдлийг суурилуулахад туслав.

Энэхүү тусламжаар Рафаэл тариалангийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, хортон шавжийн эсэргүүцлийг сайжруулсан байна. Тэрээр маш амжилттай байсан тул Замбигийн Ай Ди И сонгино, улаан лооль, газрын самар зэрэг бусад тариалангийн үйлдвэрлэлийн талаар тариаланчдыг сургахаар түүнийг сонгосон нь хоол хүнс, орлогын хүртээмжийг дээшлүүлэх замаар бусдыг адислах боломжтой болгожээ.



Зүүн гар талд: Энэтхэгийн хараа зүйн төвд хараа зүйн тусламж авч буй гэр бүл. Баруун гар талд: Тайландад хүнсний ногооны цэцэрлэгтээ ажиллаж буй хоёр эрэгтэй.

Хүмүүнлэгийн төсөл - 305

Боловсролд чиглэсэн
төсөл - 81

Эмнэлгийн нөхцөл
сайжруулах төсөл - 78

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон нутагт эмнэлэгт хэвтэж буй өвчтэй нэгнийг эргэж тойр.
- Амьдардаг газрынхаа хүүхдүүдэд заа эсвэл юм уншиж өг.
- Бусдад гараа угаах талаар болон өвдөхгүй байх хамгийн сайн аргуудыг заа.

Азид

Сүм 2023 онд хэрэгжүүлсэн бусад ажлынхаа хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсрол, цэвэр ус, ус цэвэрлэгээний асуудлуудыг шийдвэрлэхээр Ази даяар тусламж үзүүлсэн. Тусламж хэрэгтэй нэгэнд үзүүлж буй өчүүхэн хувь нэмэр хүртэл дэлхийг өөрчлөх хүчтэй гэдгийг энэ ажил харуулж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Азийн бүс нутгийн олон эмнэлэгт сургалт, орчин үеийн тоног төхөөрөмж, чанарын шаардлагад нийцсэн барилга байгууламж хомс байна. Сүм 2023 онд бүс нутаг даяар ялангуяа Камбож улсын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад анхаарсан. Тухайлбал: Сүм Кампонг Томын аймгийн эмнэлэгт хэд хэдэн барилгыг шинэчилж, шинэ тоног төхөөрөмжөөр хангаж, дурангийн мэс засал, нярайн сэхээн амьдруулахад тусламж үзүүлэх талаар ажилтнуудыг сургахад туслалцаа үзүүлсэн. Үүний үр дүнд бүс нутгийн олон мянган хүн шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг авах боломжтой болж, нөхөн сэргээх эмчилгээ богино хугацаанд үргэлжилж, нас баралтын түвшин багассан байна.

Бусад ажлын хүрээнд Сүм түүнчлэн дараах дэмжлэгийг үзүүлэв. Үүнд:

- Индонезийн хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан нярайн сэхээн амьдруулах, тогтвортой байдлын сургалт.
- Малайз улсад хэт авианы аппарат, өвчтөн зөөвөрлөх ор, эмнэлгийн бусад тоног төхөөрөмж.
- Тайландын эрчимт эмчилгээний тасагт ашиглах түргэн тусламжийн тэрэгний нурууны хавтан, дуслын систем, тарианы шахуурга.



Нэгэн ээж, охин хоёр Хонконгийн цэцэрлэгт сууж байгаа нь.

Боловсрол

Сүм 2023 онд Ази бүс даяар сурагчдын боловсролд дэмжлэг үзүүлэхээр ажилласан. Тухайлбал: Камбож улсын сурагчид сургуулийнхаа шинэ дээвэр, шал, угаалгын өрөө, усны насос, сургуулиудад зориулсан эрүүл ахуйн байгууламжийг ашиглах болсон нь тэдэнд хичээл сургуульдаа илүү анхаарах боломжийг олгосон. Үүнтэй адил Сүм Монголын Төв аймгийн засаг захиргаа, сургуулийн удирдлагатай хамтран эцэг эх нь хичээлийн хэрэгсэл авч өгөх боломжгүй сурагчдад 1000 сургуулийн цүнх хандивласан.

Цэвэр ус ба ус цэвэрлэгээ

Цэвэр ус хүртээмжтэй байх нь хүн бүрийн аюулгүй байдал, бие даах чадварыг нэмэгдүүлдэг. Туркменистан улсад Сүм Каритас байгууллагатай хамтран хоёр усны хангамжийн системийг сэргээж, өргөтгөн, ус цэвэрлэгээ, эрүүл ахуй, хог хаягдалтай харьцах аюулгүй байдлын сургалт зохион байгуулснаар олон мянган оршин суугч үр шимийг нь хүртсэн.

Сүм Монголын Багануур хотод орон нутгийн ус сувгийн хэлтэстэй хамтран нутаг дэвсгэрийн бүх шахуургын станцад хэт ягаан туяаны усаар ариутгах төхөөрөмж суурилуулав. Энэ нь Багануурын хэдэн арван мянган хүнд нутгийнхаа бүх усны шахуургын станцаас цэвэр ус авах боломжийг олгосон.

Гамшгийн дараах илүү сайхан амьдрал

Индонезийн Өрнөд Жавад болсон 5.6 магнитудын газар хөдлөлтийн улмаас Ибү, түүний нөхөр хоёр орон гэрээ алджээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, бусад төрийн бус байгууллагын тусламжтайгаар Ибүгийн нөхрийн хамт хүлээж авсан тусламжийн багц нь гэрийнхээ дээгүүр тур зуур орогнох байр барихад тусалсан ба тэд амьдралаа дахин босгож эхлэв. Уг тусламжийн үр дүнд Ибү жижиг дэлгүүр нээж, гэр бүлээ тэжээх орлого олж эхлэн, улмаар энэ нь тэднийг гамшгийн дараа хөл дээрээ босоход тусалсан.

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхийн өнцөг булан бүрийн нэн эмзэг бүлэгт хамгийн хэрэгцээтэй үед нь амин чухал тусламж үзүүлэх боломжийг бидэнд олгодог.”

КЭРРИ МУРРИ, АНУ ДАХЬ ШЭЛТЭРБОКС (SHELTERBOX)-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Боловсролд чиглэсэн төсөл - 99

Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээнд чиглэсэн төсөл - 54

Онцгой байдлын
тусламжийн төсөл - 28

Өмнө зураих гэрэлт ирээдүйгээ харсан нь

Соломон арал дахь их сургуулийн мэргэжлийн зөвлөх Жэймс чихрийн шижин өвчний шалтгаант харааны хүндрэлийн улмаас хараагаа алдсан юм. Энэ бэрхшээл нь түүний ажил эрхэлж, бага насны хоёр хүүхдээ асран халамжлах чадварт нь саад болж байв. Жэймс тус улсын бүсийн нүдний эмнэлгийн төвөөр дамжуулан эргээд хараа орох боломжтой болтлоо есөн сарын турш хараагүй явсан юм. Сүм Фред Холловс Фаундэйшн Эн Зи (Fred Hollows Foundation NZ) байгууллагад хагалгааны тоног төхөөрөмжийг хандивласны ачаар уг хагалгааг хийх боломжтой болжээ.

Жэймс: “Би дахин харах болсондоо Их Эзэнийг магтаж байна. Миний ирээдүй одоо гэрэлтэж байна” гэж хэлэв.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Хүүхдэд юм уншиж өг.
- Хөршөө эмчид үзүүлэхэд нь хүргэж өг.
- Амин дэмээр баялаг хоол хийж сураад, сурснаа найз нөхөд, гэр бүлийнхэндээ хуваалц.

Австрали, Филиппин, Номхон далайн бүс нутагт

Номхон далайн оршин суугчид хар салхи, үер, галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт олон удаа өртдөг. Олон газарт цэвэр ус, боловсролын хэрэгцээ байна. Сүм тулгамдсан асуудал бүрийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцсоор ирсэн.

Байгалийн гамшиг

2023 онд Номхон далайн орнуудын олон сургууль хар салхи, үерийн улмаас хохирол амссан. Сүм гамшгийн эсрэг анги танхим засварлаж шинэчлэх барилгын материал, тавилгаар хангах байдлаар тусламж үзүүлэв. Сүм Австрали дахь Баруун Төв бүсэд болсон сүйрлийн үерийн дараа сэргээн босгох ажилд дэмжлэг үзүүлсэн.

Боловсрол

Сүм Филиппинд Ворлд Поссибл (World Possible) байгууллагатай хамтран интернэтийн холболтгүй алслагдсан сургуулиудын сурагчдад чанартай боловсрол хүргэхээр РЭЙЧЛ (RACHEL) сервер хэмээх интернэтийн төхөөрөмж суурилуулсан.

Цэвэр ус ба ус цэвэрлэгээ

Байнгын ган гачиг, далайн түвшний өсөлт нь Кирибати арлын оронд усны гамшиг нүүрлэхэд хүргэсэн. Захын арлуудын усны эх үүсвэрийн давсны агууламж нь ундны усны аюулгүй байдлыг улам дордуулав. Сүм Си Ди И Сюз Пасифик (CDE Suez Pacific) байгууллагатай хамтран 5000 оршин суугчийг ирэх жилүүдэд уух суураар хангах ус давсгүйжүүлэх төхөөрөмжийг захын таван аралд суурилуулсан.



Австралид залуу эмэгтэй үйлчлэлийн төсөлд оролцож байгаа нь.

Карибын бүс нутагт

Сүм 2023 онд Карибын бүс нутагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт дээр төвлөрч ажилласан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Доминикан улсад Сүмээс олгодог тэтгэлгийн ачаар 24 оюутан био анагаах ухааны техникчийн сургалтад хамрагдах боломжтой болсон. Сүм Санта Круз дэ Мао дахь бүс нутгийн амаржих эмнэлэгт эхчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хэт авианы оношилгооны төхөөрөмж хандивласан.

Хөдөлмөр эрхлэлт

Ажилгүйдлийг бууруулах үүднээс Сүм Инновати Фаундэйшн (Innovati Foundation)-тэй хамтран Доминикан улсын Сүмийн гишүүдэд хэрхэн бизнесээ явуулах талаар сургалт зохион байгуулжээ. Уг төслийн хүрээнд оролцогчид 6 сарын сургалтад хамрагдсан ба энэ нь тэдэнд бизнесээ өргөжүүлэх ганцаарчилсан тусламж авах боломж олгосон юм.

Тусламж авч, найдвар олох

Пүэрто Рикод дэгдсэн Фиона хар салхи Маргаритагийн гэрийг дайрахаас өмнө тэрээр амьдралдаа олон шуургыг тэсэж гарч байжээ. Хэдий тийм ч гэрээсээ гарч, хэрэгтэй зүйлсээ авах нь нас нь ахиж яваа түүний хувьд хэцүү зүйл болж эхлэв.

Аз болоход, харьяа газрынх нь сайн дурынхан түүнд саван, үсний шингэн саван, оо зэргийг багтаасан ариун цэврийн багц авчирч өгчээ. Сүмээс санхүүжүүлсэн ХӨҮП (HOPE) төслөөр тараасан ийм багцыг Маргаритагийн адил өндөр настан, эмзэг бүлгийнхэнд туслах зорилгоор бэлдсэн.

Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээнд чиглэсэн төсөл - 28

Онцгой байдлын тусламж
үзүүлэх төсөл - 26

Боловсролд чиглэсэн төсөл - 22

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Өөрийн нийгэм дэх ашгийн бус байгууллагад сайн дураараа ажилла.
- Орон нутгийнхаа иргэний төлөөлөгчидтэй уулзаж, олон нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд онцгой анхаарал тавих талаар суралц.
- Найздаа бизнесээ эхлүүлэхэд туслах Сүмийн бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийн нэгийг танилцуул.

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхийн өнцөг булан бүрийн хүүхдүүдэд амь нас аврах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүнсний тэжээлийг хүргэх НҮБ-ын Хүүхдийн Сангийн зорилгыг дэмжиж, тууштай ажилласаар ирсэн.”

— МАЙКЛ Ж. НЕЭНХУИС
АНУ-ЫН НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Доминикан улсын мэс засалч хагалгааны ажилдаа бэлтгэж байгаа нь.



Зүүн гар талд: Боливийн нэгэн гэр бүл бага насны хүүхдүүддээ тэжээллэг хоол өгч байгаа нь. Баруун гар талд: Перуд үйлчлэл хийж буй хүн.

Боловсролд чиглэсэн төсөл - 39

Онцгой байдлын тусламжийн төсөл - 33

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чиглэсэн төсөл - 75

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Байгалийн гамшигт өртсөн хүмүүст тусалдаг орон нутгийнхаа ашгийн бүс байгууллагад сайн дураараа ажилла.
- Орон нутгийнхаа сургуулиудад хичээлийн хэрэгсэл хандивла.
- JustServe.org вэбсайтаас бүс нутгийнхаа өвчтэй хүмүүст туслах боломжийг хайж ол.

Төв ба Өмнөд Америкт

2023 онд Сүмийн Төв болон Өмнөд Америкт явуулсан хүмүүнлэгийн ажил дийлэнхдээ онцгой байдлын тусламж, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэгт төвлөрсөн.

Байгалийн гамшиг

Хэрэгжүүлсэн бусад ажлын дотор Сүм орон нутгийн удирдагчидтай хамтран Бразилийн Сан Паулу хотод үер, хөрсний гулгалтад өртсөн хүмүүст тусламж үзүүлэв. Хандивт гудас, бусад цагаан хэрэглэл, эрүүл ахуйн, цэвэрлэгээний хэрэгслүүд багтсан. Сүмийн гишүүд тусламж хэрэгтэй хүмүүст зориулсан хандивыг хуваарилах тал дээр сайн дураараа идэвхтэй оролцож, чухал үүрэг гүйцэтгэжээ.

Үүнтэй адил Чили улс даяар тархсан ой хээрийн хэд хэдэн гал түймэр болох үед Сүм тусламж үзүүлэхээр дайчлан оролцсон. Орон нутгийн иргэдийг хог хаягдал цэвэрлэхэд туслах хэрэгслээр хангаснаас гадна орон нутгийн Сүмийн удирдагчид эвдэрсэн усны холболтыг дахин сэргээх зохицуулалтуудыг хийсэн. Сүмийн гишүүд түүнчлэн галд өртсөн хүмүүст туслах хандивын хоол, живх, ариун цэврийн хэрэгслүүдийг бэлтгэж, цуглуулахаар жагсжээ.

Боловсрол

Уругвайн Монтэвидео хотод Сүмийн зуу зуун залуу гишүүн алслагдсан сургуулиудын сурагчдад зориулж хичээлийн хэрэгсэл багц бэлдэх ажилд сайн дураараа оролцжээ. Үүний үр дүнд бүс нутаг даяар хичээлийн ирц нэмэгдэж, сурлага сайжирсан.

Мөн Сүм сурагчдын сурлагыг дэмжих үүднээс анги танхим засварлаж, хандивын тоног төхөөрөмжөөр хангав. Жишээлбэл: Сүм Панамын сурагчдад зайнаас суралцах боломжийг илүү нээлттэй болгохын тулд Боловсролын Яаманд нь хэдэн зуун ширхэг компьютер хандивлажээ.



Зүүн гар талд: Эль Сальвадорын сурагчид харааны шил хүлээн авч байгаа нь. Баруун гар талд: Чили улсад дэгдсэн хээрийн түймрийн дараах цэвэрлэгээнд оролцож буй хүн.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

2023 онд Төв болон Өмнөд Америкийн Сүмийн гишүүд орон нутгийнхаа эмнэлэг, өвчтөнүүдийг дэмжихийн тулд цусаа хандивлах аянд оролцжээ. Мөн Сүм бүс нутаг даяарх эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээнд зориулж тоног төхөөрөмж, сургалтаар хангаж, бусад дэмжлэгийг үзүүлсэн. Жишээлбэл: Сүм Эль Сальвадорд Санта Анагийн Нэрэмжит Үндэсний Институттэй хамтран зуу зуун сурагчид харааны шил хандивласан.



Перуд үйлчлэлд оролцож буй залуу эрэгтэй.

Зорилгод хүргэх зэмсэг

Гватемалын залуу эмэгтэй Шерли олон жил өөрийн гэсэн тэргэнцэр худалдан авах боломжгүй байжээ. Оронд нь тэрээр хүний тэргэнцэр түр авч хэрэглэдэг байсан бөгөөд харамсалтай нь, тэргэнцэр өөрийнх нь нөхцөл байдал, бие махбодын хэрэгцээнд таардаггүй байв.

Харин 2023 онд тэр бүх зүйл өөрчлөгдөв. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, Фундабиэм Гуатэмала (Fundabiem Guatemala) хоёрын хамтын ажиллагааны ачаар Шерли хэрэгцээндээ тохируулж болох тэргэнцэртэй болжээ. Тэрээр: “Энэ тэргэнцэр . . . зорилгод минь хүргэх боломж олгосон зэмсэг байх болно” гэж хэлэв.¹⁵

“Сүм Төв болон Өмнөд Америк, Африк дахь хөтөлбөрүүдийг дэмжиж, цэвэр ус, ус цэвэрлэх үйлчилгээг тогтвортой хүргэх загварын ач холбогдлыг харуулах бидний хамгийн их нөлөө бүхий түншүүдийн нэг байсаар ирсэн.”

— САМСОН ХАЙЛУ-БЭКЭЛЭ,
ВАТЭР ФОР ПИЙПЛ (WATER FOR PEOPLE)-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**Онцгой байдлын
тусламжийн төсөл - 79**

**Дайжсан хүмүүст туслахад
чиглэсэн яаралтай
тусламжийн төсөл - 37**

**Хүн амын эмзэг бүлэг рүү
чиглэсэн төсөл - 242**

**Сэтгэлзүйн болон бие
махбодын эрүүл мэндийн
тусламж үйлчилгээ үр дүнгээ
өгдөг**

Украинд зөрчилдөөн гаарч, Ольгагийн хотыг сүйрүүлэх үед тэрээр гэр бүлийнхэнтэйгээ орон гэрээ орхиноос өөр аргагүйд хүрчээ. Энэ үйл явдал түүний гэр бүлд сэтгэцийн болон биеийн эрүүл мэндэд маш их хохирол учруулснаас гадна тэдэнд байр хөлслөх мөнгө ч байсангүй. Аз болоход, тэд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, Хүний эрхийн төлөө эмч нар (Physicians for Human Rights) байгууллагын хамтын ажиллагаагаар дамжуулан тусламж хүлээн авчээ.

Энэ төслөөр дамжуулан Ольга шаардлагатай орогнох байр, эмнэлгийн үйлчилгээ болон сэтгэл зүйн тусламж авах боломжтой болов. “Бидэнд анхаарал халамж тавьж, тусалдаг бүх хүнд бид маш их талархаж байна” гэж Ольга хэлжээ.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Амьдардаг газартаа хүн амын эмзэг бүлгийн хэрэгцээний талаар олж мэд.
- Амьдралдаа зовлон бэрхшээл туулж болзошгүй найз нөхөр, хөршөө тайтгаруул.
- Нийгмийн цэвэрлэгээний төсөлд сайн дураараа оролц

Европт

2023 онд Сүмийн Европт хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн төслүүд голдуу иргэний зөрчилдөөн, байгалийн гамшигт өртсөн хүмүүст туслахад төвлөрсөн ба тэдний олонд нь орогнох байр мөн үндсэн хэрэгцээний зэрэгцээ сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай болсон байв.

Онцгой байдлын тусламж

Сүм Туркийн Онцгой Байдлын Ерөнхий Газар, Эрүүл Мэндийн Яамтай хамтран 2-р сард болсон хүчтэй газар хөдлөлтийн улмаас сүйрэлд өртөгсдөг өргөн далайцтай тусламж үзүүлжээ. Уг хамтын ажиллагааны хүрээнд явуулын таван эмнэлэг, сууцны зориулалтаар 500 чингэлэг байршуулж, хүнс, ус, ариун цэврийн багц тарааж, олон мянган гэр бүл, хувь хүнд тусалсан.

Хүн амын эмзэг бүлэгт туслах

2023 онд Европын зарим хэсэгт зөрчилдөөнөөс юм уу хувийн асуудлаас болж орон байраа хадгалж үлдэхэд хүндрэлд орсон хүмүүсийн тоо огцом өссөн байна. Сүм Италид орон гэргүй хүмүүст туслахаар Прогетто Арка (Progetto Arca) зэрэг хэд хэдэн төсөлтэй хамтран хувцас хунар, хоол хүнс тараажээ. Үүний хүрээнд долоон хотод явуулын гал тогоо ажиллаж, хүмүүст халуун хоолоор үйлчлэв.

Сэтгэцийн болон биеийн эрүүл мэнд

Сүм Украинд үргэлжилж буй мөргөлдөөнөөс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн, дайжсан хохирогчдод сэтгэлзүйн анхны тусламж үзүүлж, сэтгэл санааны анхаарал халамж тавьжээ. Сүмийн Португал дахь сайн дурынхан мөн хөхний хорт хавдрын судалгааг дэмжих үүднээс таниулан сурталчлах тууз хийсэн. Сүм мөн Орост харааны согог, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах төхөөрөмж хандивлажээ.



Зүүн гар талд: Зөвлөхүүдээс Украины дүрвэгсдийн бүлэг сэтгэл санааны дэмжлэг авч буй нь. Эм И Ди Юу (MEDU)-ийн гэрэл зураг. Баруун гар талд: Ромд орон гэргүй хувь хүмүүс хоол, хувцсанд дугаарлан зогсож буй нь. Прогетто Арка (Progetto Arca)-ийн гэрэл зураг.

Ойрх Дорнодод

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Газын зурвас, Израил дахь олон улсын тусламжийн олон тооны төлөөлөгчтэй хамтран бусад хэрэгцээ дундаас эмнэлгийн болон сэтгэцийн эрүүл мэндийн нэн чухал тусламж үйлчилгээний төсөлд санхүүгийн эх үүсвэрийн дэмжлэг үзүүлсэн. Үүнээс гадна Сүм Ойрх Дорнодод олон төрлийн хэрэгцээг шийдвэрлэхийн тулд эрүүл мэндийн болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж, хүн амын эмзэг бүлэгт тусламж үзүүлсэн.

Эрүүл мэндийн үйлчилгээ

Иракийн Курдистаны бүс нутагт Сүм Эх барихуй, хөгжлийн төвийг үргэлжлүүлэн дэмжин ажилласан. Орон нутгийн засаг захиргаа, байгууллагуудтай хамтарсан энэхүү өрнүүн ажиллагаа нь бүс нутаг дахь эх баригч, сувилагчдад сургалт өгч, дэмжих замаар эх нялхсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилготой. Уг төсөл нийгмийг хүчирхэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг нэн чухал байгааг онцлон харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлт

Сүм 2023 онд Ойрх Дорнодод хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн ажилд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлсэн. Жишээ нь: Сүм Иордан дахь газар авсан ажилгүйдлийг бууруулах тал дээр Христийн Шашинтан Залуу Эмэгтэйчүүдийн Холбоо (ХШЗЭХ)-той хамтран ажилласан. Уг хамтын ажиллагаагаар Сүмээс санхүүжүүлсэн мэргэжил сургалтын хөтөлбөрүүд нь Иорданы иргэдэд болон олон олон сири хүмүүст ур чадварт суралцах, ажилтай болоход нь тусалжээ.

Хүн амын эмзэг бүлэгт зориулсан тусламж

Мороккод үзүүлсэн хүмүүнлэгийн тусламж нийгмээрээ голдуу үл анзаардаг хүн амын хэсэгт дорвитой нөлөө үзүүлж байна. 2023 онд хэрэгжүүлсэн бусад ажлын дунд Сүм Пассэрэллын Аутизмтай Иргэдийн Төвд гадаах үйл ажиллагааны талбай, дотуур байр барьж өгчээ. Энэ төв аутизмтай өсвөр үеийнхэнд бие даахад шаардлагатай үндсэн чадваруудыг болон хөдөө аж ахуй, спорт, дуу хөгжим, урлагаар төрөлжсөн ур чадварыг заадаг. Эндэх үйл ажиллагаа нь төвийн залуучуудын ажилд орох боломжийг нэмэгдүүлж, аж амьдралыг нь дээшлүүлж байна.

Эмэгтэйчүүд, хүүхдүүд
рүү чиглэсэн төсөл - 53

Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээнд чиглэсэн төсөл - 25

Онцгой байдлын
тусламжийн төсөл - 78

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон нутгийнхаа эмнэлэгт хүүхдийн хөнжил хандивла.
- Нийгэмдээ хүүхдүүдэд зориулан эрүүл ахуй, ус цэвэрлэгээний талаар заа.
- Орогнох газар хайж буй дүрвэгсдэд тусалдаг нүүлгэн суурьшуулах төвд сайн дураараа ажилла.

Пакистан дахь үерийн дараах нөхөн сэргээлт

Пакистанд Гуламын тосгон үерт автах үед тэрээр нөхөртэйгөө гэрээсээ эд зүйлээ гаргахад хэцүү байжээ. Өөрөө жирэмсэн, нөхөр нь тусгай хэрэгцээтэй учраас тэд орлогын ганц эх үүсвэр болох малаа аварч чадаагүй байв.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Исламын Халамж Үйлчилгээ, АНУ дахь Шэлтэрбокс (ShelterBox)-той хамтран Гуламд болон үерт өртсөн гэр бүлүүдэд мөнгөн тусламж олгожээ. Үүний ачаар Гулам хүнс, хувцас мөн гэр бүлийн бизнесээ дахин эхлүүлэхээр ямаа худалдан авч, амьдралаа босгож эхлэв.



Пакистан гэр бүл гэр нь үерт автсаны дараа орогнох байрт цуглав. Шэлтэрбокс (ShelterBox)-ийн гэрэл зураг.



Зүүн гар талд: АНУ дахь индианчуудын суурины хувь хүмүүст туслахаар залуу эрэгтэйчүүдийн удирдагчид мод ачиж байгаа нь. Баруун гар талд: Сайн дурынхан Калифорниад орон гэргүй хүмүүст орогнох байр бэлдэж байгаа нь.

**Хүүхэд, эмэгтэйчүүдэд
туслахад чиглэсэн төсөл - 200**

**Орогнох байр, орон
байрны төсөл - 170**

**Цэвэр ус, хүнсний аюулгүй
байдлыг хангах төсөл - 261**

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Орон гэргүй хүмүүсийг хоолоор дайл.
- Дүүрэг, хорооныхоо хүнсний хандивын аяныг ивээн тэтгэ.
- Ойр тойрныхоо хүүхэд, эмэгтэйчүүдийн хэрэгцээний талаар судал. Сурсан мэдсэнээ найз нөхөд, гэр бүлийнхэндээ ярь.

Хойд Америкт

Сүм 2023 онд Хойд Америкт хүмүүнлэгийн олон төсөл хэрэгжүүлсний дотор орон гэргүй, хүнсний аюулгүй байдал алдагдсан, хүчирхийлэл, байгалийн гамшигт өртсөн хувь хүмүүст ихээхэн хэмжээний тусламж үзүүлсэн.

Орон байр

Сүм Канадад хамгийн удаан хугацаагаар үйл ажиллагаагаа явуулж буй Олд Брюэри Мишн (Old Brewery Mission) байгууллагын орогнох байранд санхүүгийн тусламж үзүүлсэн. Энэхүү хандив нь орогнох байрын барилга байгууламж, үйлчилгээг шинэчилж, илүү аюулгүй эрүүл орчин, оршин суугчдын хувийн орон зай, нэр хүндийг дээшлүүлсэн. Шинэчлэн засварласан орогнох байранд одоогоор шөнөдөө 197 хүн хоноглох боломжтой боллоо.

Сүм мөн эх орноосоо дүрвэсэн эсвэл орогнол хайсан хувь хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх тал дээр олон тооны байгууллагатай хамтран ажилласан. Дээрх байгууллагуудад Католик Бишопуудын Америкийн Нэгдсэн Улсын Чуулган (United States Conference of Catholic Bishops), Олон Улсын Аврах Хороо (the International Rescue Committee), Америкийн Нэгдсэн Улсын Дүрвэгсэд, Цагаачдын Хороо (the United States Committee for Refugees and Immigrants), бусад орон нутгийн олон олон агентлаг ордог. Сүм Ал-Масбаах (Al-Masbaah) агентлагтай хамтран, Калифорния мужийн Сакраментод шалан дээр унтаж байсан дүрвэгсдэд зориулан 500 хөөсөн гудас, бусад хэрэглэл худалдан авч, тусламж үзүүлжээ.

Хоол хүнс, ус

Сүм Мексикт Пачүкилла хэмээх 40 орчим өрхтэй жижиг тосгонд борооны ус хуримтлуулах систем хоёрыг суурилуулахаар Бийлдинг Хөүп Сан (Building Hope Foundation)-тай хамтран ажиллав. Уг систем нь ус зайлуулах хоолой, шүүлтүүр, нөөцийн савтай ба гэр бүлүүдийг цэвэр устай, ногооны усалгаатай байх боломжоор хангасан.



Зүүн гар талд: Сайн дурын ажилтнууд Күзбэк дэх Олд Брюэри Мишн (Old Brewery Mission)-д оройн хоолны үйлчилгээ үзүүлж буй нь. Баруун гар талд: Хүүхдэдэйгээ нэгэн эмэгтэй Чикагогийн Ситивайд нийгэмлэгийн хүүхдийн угаалга ёслол (Chicago Citywide Community Baby Shower) дээр.

Америкийн Нэгдсэн Улсад Сүм хүнсний тусламж хэрэгтэй хүмүүст туслахаар Фийдинг Америка (Feeding America) байгууллагад мөнгө хандивлажээ. Мөн улс даяарх хүнсний томоохон хандивын аянуудад Сүм зуу зуун чингэлэг хүнс хандивласан.

Сүм бишопын агуулахаас Канадын Албэрта дахь Мастард Сийд (Mustard Seed) энэрлийн байгууллагад бараа хандивлаж, Форт Саскачуан (Fort Saskatchewan), Дэйли Брэд (Daily Bread) хүнс хандивлах сангуудад мөнгөн дэмжлэг үзүүлснээр хүнс тараах хүчин чадлыг нь нэмэгдүүлжээ.

Эмэгтэйчүүд ба хүүхдүүд

Сүм Америкийн Нэгдсэн Улс дахь Христ доторх Бурханы Сүм (Church of God in Christ)-тэй хамтран 400 гаруй жирэмсэн эхийг нийгмийн үйлчилгээтэй холбож өгч, шинэ хүүхдийн угаалга ёслолыг ивээн тэтгэв. Өмнөд Чикаго дахь хар арьст эхчүүдийн урьдчилан сэргийлэх боломжтой нас баралттай тэмцэхийн тулд Сүм эрсдэлтэй эхчүүдийг шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах, дула (doula) сургалтыг нэмэгдүүлэхээр Мэланэйтэд Мидвайвс (Melanated Midwives) байгууллагатай хамтран ажиллаж байна.

Мөн хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бусад хүчирхийллээс хамгаалах төслүүдийг хэрэгжүүлсэн. Сүм тусламж хэрэгтэй эмэгтэйчүүдэд туслах хамгаалах байрны багтаамжийг сайжруулах зорилгоор Христийн Шашинтан Залуу Эмэгтэйчүүдийн Холбооны Сэйф Чойс Гэр Бүлийн Хүчирхийллээс Хамгаалах Төв (YWCA SafeChoice Domestic Violence Shelter)-д гэр ахуйн бараа, цагаан хэрэглэл, гал тогооны хэрэгсэл, агаар хөргүүр гэх зэргийг хандивлажээ. Хандив тусламж, засвар шинэчлэлийн ачаар уг төв ирэх жилүүдэд 400 гаруй хувь хүнд үйлчлэх боломжтой болоод байна.

Орон гэргүй байдлыг даван туулах, буцааж өгөх

Калифорниагийн Нэка гэх нэгэн эмэгтэй охин, зээ хүүхдүүдийн хамт байрнаасаа хөөгдөх үед донтолтойгоо тэмцэж байв. Тэрээр амьдрах шинэ байх хайн явахдаа “Би хаа сайгүй л тусламж гуйсан ч хэн ч биднийг оруулаагүй. Эцэст нь, Бэй Ариа Рэскю Мишн (Bay Area Rescue Mission) л зөвшөөрсөн дөө” гэж хэлсэн юм.¹⁶

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Бэй Ариа Рэскю Мишн (Bay Area Rescue Mission)-той хамтран Нэка шиг хувь хүмүүсийг түр орогнох байранд байрлах, ажил хөдөлмөр эрхлэх, бэрхшээлийг даван туулж, хөл дээрээ босоход нь тулгардаг бэрхшээлийг даван туулахад шаардлагатай тусламжийг үзүүлжээ. Нэка энэ тусламжийн үрээр донтолтоосоо ангижирч, амьдралынхаа гол анхаарах зүйлийг дахин олж аваад, бусад хүүхэд, эмэгтэйд туслах замаар хариу барих боломжтой байсан хэмээн хэлсэн.


“Та бүхний чин сэтгэлийн хувь нэмэр [эмэгтэйчүүд, хүүхдүүдийн] амьдралд ихээхэн өөрчлөлтийг авчирсан.”

—СТЭФАНИ СЮВЭЛЛ,
БЭЙ АРИА РЭСКЮ МИШН (BAY AREA RESCUE MISSION), ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Танд баярлалаа

Бид Сүмийн гишүүд, найз нөхөд та бүхэндээ өнгөрсөн жилийн хугацаанд тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах бидний ажилд маш олон арга замаар оролцсонд талархлаа илэрхийлж байна. Дэлхий даяарх гай зовлонд нэрвэгдсэн хүмүүсийн төлөө гэсэн та бүхний хайр энэрэл, өгөөмөр сэтгэл байгаагүй бол энэ ажил боломжгүй байх байсан. Хөршүүддээ туслалцаа үзүүлэх арга замыг үргэлжлүүлэн эрэлхийлдэг та бүхэнд бид талархаж байна.

Энэ ажилд нэмэрлэсэн бүх хандив, сайн дураар зориулсан цаг, залбирлын тань төлөө танд гялайлаа. Өчүүхэн ч гэсэн хүчин чармайлт бусдын оруулсан хувь нэмэртэй хосолсон үед ер бусын гайхамшигт ажлыг гүйцэлдүүлдэг. Та бүхний хийсэн үйлчлэл та нарыг илүү амар амгалан, ирээдүйд найдах илүү гэрэл гэгээтэй итгэл, дэлхийн өнцөг бүрд буй Бурханы бүх хүүхдийг гэсэн илүү энэрэл хайраар адисалсан гэдэгт бид найдаж байна.



Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж


Дэлхий даяарх хүмүүнлэгийн ажлын тухай дэлгэрэнгүй унших, нийгэмдээ оролцоотой байхыг хүсвэл дараах хаягуудаар биднийг дагаарай. Үүнд:



[@Caring.ChurchofJesusChrist](#)
[@DeseretIndustriesThrift](#)
[@JustServe.org](#)



[@Caring.ChurchofJesusChrist](#)
[@DeseretIndustries](#)
[@Just_Serve](#)



Сүмийн халамж үйлчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [Caring.ChurchofJesusChrist.org](#) вэбсайтаас үзээрэй.



Зүүн талын кодоор JustServe аппликэйшныг татан авч, харьяа газрынхаа сайн үйлсийн аянд оролцоорой.

Дараах хаягуудаар биднийг дагаж, дэлгэрэнгүй мэдээлэл аваарай:

[ChurchofJesusChrist.org](#) | [Caring.ChurchofJesusChrist.org](#) | [JustServe.org](#) | [DeseretIndustries.org](#) | [AddictionRecovery.ChurchofJesusChrist.org](#)

Эх сурвалж

1. Patrick Kearon, in "A Conversation with Elder Patrick Kearon" (video), Newsroom, Dec. 8, 2023, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/elder-patrick-kearon-called-quorum-of-the-twelve-apostles>.
2. Camille N. Johnson, in "The Church of Jesus Christ Launches Global Effort to Nourish Children and Mothers," Newsroom, Nov. 9, 2023, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/the-church-of-jesus-christ-launches-global-effort-to-nourish-children-and-mothers-relief-society>.
3. Kristin M. Yee, in "Thematic Session—SDG 1 No Poverty" ("Why It Matters": The 1st International Academic Conference on the Sustainable Development Goals, Oct. 6, 2022).
4. Гэррит В.Гонг, "Бидэнд хайр байдаг юм," Лиахона, 2023 оны 11-р сар, 112.
5. Preston Dean, in "Service Missionaries Help People Come to Christ," Newsroom, Mar. 24, 2023, newsroom.churchofjesuschrist.org/article/church-service-missionaries.
6. Gérald Caussé, "The Blessings Will Follow: Benefits of Implementing JustServe" (video), [ChurchofJesusChrist.org/study/video/justserve-videos/2020-10-0100-the-blessings-will-follow-benefits-of-implementing-just-serve-1080p](https://www.ChurchofJesusChrist.org/study/video/justserve-videos/2020-10-0100-the-blessings-will-follow-benefits-of-implementing-just-serve-1080p).
7. Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, "Сүнсээр өдөөгдсөн тохинуулал," 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 82
8. Даллин Х.Өүкс, "Ядуус болон гачигдагсад туслах," Лиахона, 2022 оны 11-р сар, 6.
9. Jorge Arnez, in "'Now We Just Open the Tap'—Bolivian Community Finally Gets Water Through Church's Help," Newsroom, Aug. 16, 2023, newsroom.churchofjesuschrist.org/article/now-we-just-open-the-tap-bolivian-community-finally-gets-water-through-churchs-help.
10. W. Christopher Waddell, in "Recent \$37 million in Church donations come after a year of unprecedented giving and service," Church News, Sep. 28, 2022, [thechurchnews.com/global/2022/9/28/23365257/humanitarian-donations-giving-aid-emergency-response-welfare-service-justserve](https://www.thechurchnews.com/global/2022/9/28/23365257/humanitarian-donations-giving-aid-emergency-response-welfare-service-justserve).
11. Рассэлл М.Нэлсон, "Цаг нь ирлээ," Лиахона, 2022 оны 5-р сар, 126.
12. L. Todd Budge, "The Divine Gift of Creation: Our Sacred Duty to Care for the Earth," Newsroom, newsroom.churchofjesuschrist.org/article/bishop-l-todd-budge-sacred-duty-care-for-earth.
13. Camille N. Johnson, in "Church Gives \$32 million to World Food Programme in Largest One-Time Donation to Date," Church News, Sept. 14, 2022, [thechurchnews.com/global/2022/9/14/23353487/church-gives-32-million-dollars-to-world-food-programme-largest-one-time-donation-to-date](https://www.thechurchnews.com/global/2022/9/14/23353487/church-gives-32-million-dollars-to-world-food-programme-largest-one-time-donation-to-date).
14. J. Anette Dennis, Facebook, Jun. 20, 2023, [facebook.com/RS1stCounselor](https://www.facebook.com/RS1stCounselor).
15. Shirly C., in "Church Donation Provides Mobility and Independence to Guatemalans," Newsroom, Feb. 7, 2023, newsroom.churchofjesuschrist.org/article/church-donation-provides-mobility-and-independence-to-guatemalans.
16. Nneka, "The Prodigal Grandmother," Bay Area HOPE: A Publication of the Bay Area Rescue Mission (Summer 2023), Summer 2023, 2.
17. Рассэлл М.Нэлсон, "Хоёр дахь агуу зарлиг," 2019 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 109.
18. Susan H. Porter, in "Presidents Johnson and Porter Meet with Government Leaders on Women's Issues in South America," Newsroom, Sept. 23, 2022, newsroom.ChurchofJesusChrist.org/article/presidents-johnson-and-porter-meet-with-governmentleaders-on-womens-issues-in-south-america.

"Бидний үйлс бусдын хараа, сонорт хүрэх нь ховор байдаг.
Гэхдээ Бурхан мэддэг. Тэрээр биднийг чимээгүй, үл харагдах
арга замаар үйлчлэх үед адисалдаг."

—ЕРӨНХИЙЛӨГЧ СЮЗАН Х.ПОРТЭР, ХҮҮХДИЙН ХЭСГИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧ

*“Их Дэний хүмүүс гэж нэрлэгдэх ‘хүсэлтэй
хүмүүс нэг нэгнийхээ ачааг үүрэлцэж, ... гашуудах
тэдний хамт гашуудаж; ... тайтгарал хэрэгтэй
тэднийг тайтгаруулахад бэлэн байдаг.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ РАССЭЛЛ М.НЭЛСОН,
ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ¹⁷

